



ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ



“ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН  
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ

# НОТОЛГООНЫ ОНОЛ

Гарын авлага

**Зөвлөх**

Н.Туяа

**Зохиогч**

Б.Батзориг

*Энэхүү гарын авлагыг Хууль зүйн яатнаас хэрэгжүүлж буй  
Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах”  
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар хот  
2013 он

DDC  
345.052  
H-751

## НОТОЛГООНЫ ОНОЛ

*Гарын авлага*

---

**Гарын авлага боловсруулсан баг:**

**Зөвлөх:**

Н.Туяа

**Зохиогч:**

Б.Батзориг

**Хэвлэлийн хуудас:** 6.6

**Цаасны хэмжээ:** B5

**Хэвлэсэн тоо:** 1200

**Хэвлэсэн газар:** “BCI” Хэвлэлийн компани

ISBN 978-99962-56-69-1



## ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН БАГШ, ОЮУТАН НАРТ



Монгол Улсын Засгийн газрын Хууль зүйн салбараа шинэчлэх санаачлагыг анхлан дэмжсэн хандивлагчдын тоонд Дэлхийн банк зүй ёсоор ордог билээ. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2002-2008 онуудад Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн хүрээнд эрх зүйн шинэтгэлийн чухал хэсэг болох Эрх зүйн бакалаврын боловсролын агуулга, чанарыг олон улсын түвшинд нийцүүлж, сайжруулах ажлын эхлэл тавигдсан юм. Тухайлбал, “Эрх зүйн дээд боловсролын Монгол Улсын стандарт”-ын анхны хувилбар, түүний дагуу 31 хичээлийн жишиг хөтөлбөр, эдгээрээс 14 хичээлийн оюутанд зориулсан гарын авлага зэргийг боловсруулж, сургалтын арга барилыг шинэчлэхэд чиглэсэн ажлууд хийгдсэн. Эдгээр хөтөлбөр, гарын авлагыг 2007-2008 онд эрх зүйч бэлтгэдэг бүх их, дээд сургуулиудын оюутнуудын хүртээл болгосон.

2009 оноос Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж эхэлсэн “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд дээрх ажлын үргэлжлэл болох оюутанд зориулсан нийт 20 гаруй хичээлийн гарын авлага боловсруулах ажил хийгдэж байна. Энэ ажлыг хууль зүйн салбарын нэр хүндтэй, туршлагатай эрдэмтэд, багш нар болон идэвх, санаачлагатай залуу багш нараас бүрдсэн нийт 60 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэж байна.

*Төслийн зохицуулагч  
Большорлоогийн Сафантуяа*

## ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР



Боловсрол судлаачид болон багш нар сургалт явуулах үзэл баримтлалыг боловсруулахдаа хоёр янзын хандлагыг баримталж байна. Нэг дэх нь илүү уламжлалт хэлбэрийнх бөгөөд агуулгад чиглэсэн баримтлалыг дагадаг байхад хоёр дахь нь үр дүнд анхаардаг. Агуулгад чиглэсэн хандлагаар бол сургалтын агуулгыг тухайн шинжлэх ухааны мэдлэг, ойлголт тодорхойлдог. Харин үр дүнд чиглэсэн хандлага нь мэдлэгт анхаарахаас гадна суралцагчдын ур чадвар, хандлага үнэт зүйлсийн хөгжилд анхаардаг.

1990-ээд оноос хийсэн эрх зүйн шинэчлэлт нь хууль зүйн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг шинэчлэх, боловсронгуй болгохыг шаардсан юм. Хууль зүйн яам, Дэлхийн банкны “Хууль зүйн үйлчилгээг сайжруулах” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг дэмжих” дэд төслийн боловсруулсан сургалтын хөтөлбөр, гарын авлагын шинэлэг тал нь:

- Агуулгад суурилсан хөтөлбөрөөс агуулга, үр дүнд суурилсан хөтөлбөр боловсруулсан.
- Зорилго, хүрэх үр дүнг тодорхой болгосон.
- Онолын мэдлэгийг эзэмшүүлэхийг зорихоос гадна мэргэжлийн чадвар эзэмшүүлэх, үнэт зүйлсийн төлөвшилд нь нөлөөлөх зорилго тавьсанд оршино.

*Төслийн зөвлөх  
Ухнаагийн Туяа (Ph.D)*

## ЗӨВЛӨХ



### **Нүрэнзэдийн Туяа**

*МУИС-ийн ХЗС-ийн Практик сургалтын тэнхимийн эрхлэгч*

МУИС-ийн Хууль зүйн сургуульд 1989 оноос багшилж, эрүүгийн процесс болон криминологийн чиглэлээр дагнан судалгааны ажил хийж, 1999 оноос сургалтын шинэ хэлбэр болох хууль зүйн клиник сургалтын хөтөлбөр, арга зүйг боловсруулж, 2003 оноос клиникийн чиглэлээр 4 гарын авлага, товхимол хэвлүүлжээ. Түүнчлэн олон улсын болон улсын хэмжээний эрдэм шинжилгээний бага хуралд 20 гаруй илтгэл хэлэлцүүлж, прокурорын хяналт, албадлагын арга хэмжээ, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрхийг баталгаажуулах асуудлаар гарын авлага, эрдэм шинжилгээний нийтлэл, судалгаа хийж байсан.

## ЗОХИОГЧ



### **Бадамын Батзориг**

*Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах комиссар*

1994 онд Цагдаагийн дээд сургууль төгсч, 1998 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хууль зүйн магистр, 2012 онд МУИС-д Хууль зүйн ухааны докторын зэрэг тус тус хамгаалсан.

Криминологи, Нотолгооны онол, Судалгаа шинжилгээний ажил хийх арга зүйн чиглэлээр 20 гаруй гарын авлага, нэг сэдэвт бүтээл, сурах бичгийг дангаараа буюу бусадтай хамтран бичсэн. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл бэлтгэх, боловсруулах ажлын хэсэгт оролцсон.



## ГАРЧИГ

### НЭГ. НОТОЛГООНЫ ОНОЛ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

1. Нотолгооны онол хичээлийн тодорхойлолт ..... 6
2. Нотолгооны онол хичээлийн товч агуулга ..... 9

### ХОЁР. НОТОЛГООНЫ ОНОЛ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

- Сэдэв 1. Нотолгооны онол..... 17
- Сэдэв 2. Нотолгооны ойлголт, төрөл.....20
- Сэдэв 3. Нотолгооны арга, үе шат ..... 24
- Сэдэв 4. Нотолгооны зүйл, хэмжээ, хязгаар.....29
- Сэдэв 5. Нотлох ажиллагаа..... 32
- Сэдэв 6. Нотлох баримт, түүний шинж ..... 39
- Сэдэв 7. Нотлох баримтын цогц байдал ..... 44
- Сэдэв 8. Нотлох баримтыг үнэлэх, ашиглах..... 47
- Сэдэв 9. Мэдүүлгэн нотлох баримт ..... 51
- Сэдэв 10. Биет нотлох баримт ..... 57
- Сэдэв 11. Шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг ..... 63

# НЭГ.

## НОТОЛГООНЫ ОНОЛ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

### 1. НОТОЛГООНЫ ОНОЛ ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хичээлийн нэр:	“Нотолгооны онол”
Индекс:	
Кредит цаг:	2
Нийт цаг:	40 /24 цагийн лекц, 16 цагийн дасгал/

#### **“Нотолгооны онол” хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага**

Нийгэм хөгжихийн хирээр хүн төрөлхтний дунд үүсдэг элдэв харилцааг хуулиар зохицуулах шаардлага бий болдог. Энэхүү хууль хэрэгжих нэг баталгаа нь тухайн хуулийг зөрчигдсөн эсэхийг нотлох баримтаар тогтоож зохих шийдвэр гаргахад оршдог.

Түүнчлэн хүний эрх, эрх чөлөөг дээдлэх асуудал нь нэг улсын хүрээнээс хальж, дэлхий нийтийн асуудал болсон нь төрөөс, иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх мөн түүнчлэн эрх, эрх чөлөө нь дахин зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх талаар Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд үйл ажиллагаагаа олон түмний нийтлэг хүсэл сонирхол, дэлхий нийтийн түгээмэл зарчимд нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай болжээ.

Иргэд, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээн, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд өндөр ур чадвар, мэдлэг, боловсрол бүхий оролцогчдын хуульч, шуурхай ажиллагааны үр дүнд бий болсон нотлох баримтад тулгуурлан шүүхийн шийдвэр гаргахыг нийгэм, цаг үе шаардаж байна.

**Хичээлийн зорилго:** *Аливаа хэрэг, маргаан (эрүү, иргэн, захиргаа, арбитрын болон бусад хэрэг маргааны)-ыг нотлох явцад нотолгооны ач холбогдлыг үнэлж, дүгнэлт өгч, ашиглах чадварыг эзэтшүүлэхэд хичээлийн зорилго оршино.*



### **Хичээлийн зорилт:**

1. Нотолгооны онолын ойлголт, судлах зүйл, судалгааны арга зүй, нотолгооны онолын тогтолцоо, бусад шинжлэх ухааны уялдаа холбоог тодорхойлох
2. Нотолгооны ойлголт, нийгэмд үзүүлэх нөлөөг мэдэж онолын мэдлэгийг практик ажиллагаандаа удирдлага болгох чадвартай болох
3. Нотлох баримтын онцлог, тодорхой шийдвэрт нөлөөлөх нөлөөллийг судлан шийдвэр гаргахад ашиглаж сурах
4. Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх, шалгах, ашиглахад анхаарах асуудал, практик алдаа дутагдал түүнээс гарах арга замыг тодорхойлж сурах
5. Нотлох үйл ажиллагааны тусгай төрлийг практикт ашиглах чадвартай болох
6. Нотолгооны явцад бий болдог элдэв хүндрэл, бэрхшээлийг даван туулах, шийдвэр гаргахад хууль зүйн үндэслэлтэй гаргах
7. Нотлох баримтыг үнэлэн тэдгээрийн уялдаа холбоо, зүй тогтлыг онолын төдийгүй практикийн хувьд танин мэдэх, нэг эрх зүйн маргаанаас өөр эрх зүйн хэрэг, маргааны тодорхой шийдвэр гаргахад ашиглах анхан шатны ур чадвар эзэмшүүлэх

### **Залгамж холбоо:**

“Нотолгооны онол” нь эрүү, иргэн, захиргааны эрх зүй зэрэг материаллаг эрх зүй түүнчлэн процессийн эрх зүй дээр тулгуурладаг тул тухайн хичээлүүдийг үзэж судалсан байх шаардлагатай. Тэдгээрээс гадна өмгөөллийн эрх зүй, өмгөөллийн тактик, арга зүй, криминалистик, криминалистикийн тактик хичээлийг судалсан байна. “Нотолгооны онол” хичээлтэй Гэмт хэрэг зүйлчлэлийн онол, Шүүх эмнэлэг, Шүүх ня-бо зэрэг хичээлүүдтэй зэрэгцүүлэн судалж болно.

### **Нотолгооны онол хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, цагийн хуваарилалт**

Хичээл заах багш, тухайн сургуулийн сургалтын тэргүүлэх чиглэл, оюутны мэргэшин суралцах хүсэл сонирхол, сургалтын хэрэглэгдэхүүний хангамж хүрэлцээг харгалзан сэдвийн сонголт, цагийн хуваарийг хийнэ. Хичээлийн үндсэн сэдэв, тэдгээрийг заах хэлбэр, цагийн хуваарилалтыг жишиг байдлаар гаргалаа.

# НОТОЛГООНЫ ОНОЛ

ГАРЫН АВЛАГА

	Сэдэв	Хичээл явуулах хэлбэр		Нийт цаг
		лекц	дасгал	
1	Нотолгооны онол	2		2
2	Нотолгооны ойлголт, төрөл	2	1	3
3	Нотолгооны арга, үе шат	2	1	3
4	Нотолгооны зүйл, хэмжээ, хязгаар	2	1	3
5	Нотлох ажиллагаа	2	1	3
6	Нотлох баримт, түүний шинж	2	2	4
7	Нотлох баримтыг цогц байдал	4	2	6
8	Нотлох баримтыг үнэлэх, ашиглах	4	2	6
9	Мэдүүлгэн нотлох баримт	2	2	4
10	Биет нотлох баримт	2	2	4
11	Шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг	2	2	4
	Нийт 40 цаг	24	16	40





## 2. НОТОЛГООНЫ ОНОЛ ХИЧЭЭЛИЙН ТОВЧ АГУУЛГА

### СЭДЭВ 1. НОТОЛГООНЫ ОНОЛ

**Сэдвийн товч агуулга:** *Нотолгооны онцлог, ач холбогдол. Хүний жирийн амьдрал, шинжлэх ухаан танин мэдэхүй, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцад нотолгооны гүйцэтгэх үүрэг. Мэтгэлцүүлэх, төрдөн шүүх болон холимог загварын нотолгооны онцлог.*

### СЭДЭВ 2. НОТОЛГООНЫ ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ

**Сэдвийн товч агуулга:** *Нотолгооны ойлголт, зорилго, нотолгооны үнэн, түүний шинж. Нотолгооны төрөл, төрийн болон хувийн нотолгооны ойлголт, онцлог, ялгагдах шинж, түүнийг судалсаны ач холбогдол.*

### СЭДЭВ 3. НОТОЛГООНЫ АРГА, ҮЕ ШАТ

**Сэдвийн товч агуулга:** *Хэрэг маргааны нотолгооны түгээтэл арга, анализ, синтез, индукци, логик, харьцуулалт, системчлэх зэрэг сэтгэхүйн аргуудыг хэрэглэх. Хэргийн нотолгооны тусгай арга, уламжлалт ба уламжлалт бус аргууд, тэдгээрийн үүсэл, онцлог. Хэргийн нотолгооны үе шат, тэдгээрийн онцлог.*

### СЭДЭВ 4. НОТОЛГООНЫ ЗҮЙЛ, ХЭМЖЭЭ, ХЯЗГААР

**Сэдвийн товч агуулга:** *Нотолгооны зүйлийн ойлголт, түүнийг зөв тодорхойлохын ач холбогдол, нотолгооны үндсэн ба нэмэлт нотолгооны зүйлийн ойлголт. Хэрэг маргааны нотолгооны хэмжээ болон хязгаарын ойлголт, тэдгээрийг оновчтой тогтоосны үр дагавар, тогтооход нөлөөлөх хүчин зүйлс.*

## СЭДЭВ 5. НОТЛОХ АЖИЛЛАГАА

**Сэдвийн товч агуулга:** *Хэргийг нотлох ажиллагааны ойлголт, хэлбэр /нотлох ажиллагааны зарчим, баталгаа, нотлох баримт халгаалах, тээвэрлэх, оролцогчдод эрх үүргийг нь тайлбарлан өгөх, нотолгооны нууцлалыг хангах/, нотлох ажиллагааны үед хэрэглэх эрх зүйн албадлага, Нотлох баримт цуглуулах болон бэхжүүлэх ажиллагааны ойлголт, онцлог, шинжлэх ухаан технологийн ололтыг ашиглах, нотлох баримт цуглуулах бэхжүүлэх ажиллагааны журам зөрчсөнөөс үүсэх үр дагавар.*

## СЭДЭВ 6. НОТЛОХ БАРИМТ, ТҮҮНИЙ ШИНЖ

**Сэдвийн товч агуулга:** *Нотлох баримтын ойлголт, үндсэн /хэрэгт хамааралтай байх, эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдал нь тэдээлэл байдлаар илрэх, тэдээлэл эх сурвалжтай байх, хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл бүхий баримтын эх сурвалжийг олж авсан анхдагч эх сурвалж нь тодорхой байх, тэдээллийг нотлох баримтын эх сурвалжаас хуульд заасан үндэслэл журмын дагуу олж авсан байх шинжүүд/, нэтэлт шинж.*

## СЭДЭВ 7. НОТЛОХ БАРИМТЫН ЦОГЦ БАЙДАЛ

**Сэдвийн товч агуулга:** *Нотлох баримтыг цогц байдал, нотлох баримтын цогц байдлын гишүүн, нотлох баримтын цогц байдлын холбоос, нотлох баримтын цогц байдлын чиг үүрэг, нотлох баримтын цогц байдлын олонлог байдал, нотлох баримтын цогц байдлын үнэн бодитой байх, итгэлтэй байх, хүлээн зөвшөөрөхүйц байх, нэгдмэл байх шинжийн ойлголт.*

## СЭДЭВ 8. НОТЛОХ БАРИМТЫГ ҮНЭЛЭХ, АШИГЛАХ

**Сэдвийн товч агуулга:** *Нотлох баримтыг үнэлэх ажиллагааны ойлголт, нотлох баримтыг үнэлэхэд баримтлах үндсэн мөрдлөг Нотлох баримтыг ашиглах ажиллагааны ойлголт, нотлох баримтыг шүүхийн хэлэлцүүлгээс хасах, нотлох баримтыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хасах.*



## **СЭДЭВ 9. МЭДҮҮЛГЭН НОТЛОХ БАРИМТ**

**Сэдвийн товч агуулга:** *Мэдүүлгэн нотлох баримтын ойлголт, түүний давуу болон сул тал, мэдүүлгэн нотлох баримтын үндсэн болон нэмэлт шинж, Мэдүүлгэн нотлох баримтыг үнэлэхэд анхаарах зүйл.*

## **СЭДЭВ 10. БИЕТ НОТЛОХ БАРИМТ**

**Сэдвийн товч агуулга:** *Биет нотлох баримтын ойлголт, түүний давуу болон сул тал, мэдүүлгэн нотлох баримтын үндсэн болон нэмэлт шинж Биет нотлох баримтыг үнэлэхэд анхаарах зүйл.*

## **СЭДЭВ 11. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, МЭДҮҮЛЭГ**

**Сэдвийн товч агуулга:** *Шинжээчийн дүгнэлт, мэдүүлгийг ойлголт, түүний давуу болон сул тал, үндсэн болон нэмэлт шинж. Шинжээчийн дүгнэлт, мэдүүлгийг үнэлэхэд анхаарах асуудал.*

### **3. НОТОЛГООНЫ ОНОЛ ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН**

#### **Сурах бичиг, гарын авлага**

##### **А.Монгол хэлээр:**

1. Авлига, албан тушаалын гэмт хэрэг мөрдөх аргачлал, ерөнхий редактор Б.Батзориг, УБ., 2011.
2. Амгаланбаяр.Ц., Байцаалтанд нотлох баримтыг ашиглах нь, УБ., 1989.
3. Амгаланбаяр.Ц., Орон байрны хулгайн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах арга зүйн зарим асуудлууд, УБ., 1994.
4. Баасан.Л., Мөнхжаргал.Т., Доржготов.А., Хуяг.Д., Улаанбаатар.Б., Дугармаа.А., Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, ерөнхий анги, УБ., 1999.
5. Банзрагч.С, Гэрэлмаа.Т, Захиргааны хэрэг, маргаан хянан шийдвэрлэх зарчим, УБ.,2005.
6. Батзориг.Б., Монгол дахь нотолгооны түүхэн уламжлал-1, УБ., 2001.
7. Батзориг.Б, Гэмт хэргийн нотолгооны ерөнхий онол, УБ., 2002.
8. Батзориг.Б., Бямбаа.Ж., Сүхбаатар.Т., Эд мөрийн баримт, УБ., 2006.
9. Батзориг.Б., Зууннасан.Э., БНХАУ-ын эрүүгийн ба эрүүгийн заргын хууль, УБ., 2006.
10. Батзориг.Б, Зүмбэрэлхам.Д., Сэжигтэн, яллагдагч, гэрчийн мэдүүлэг нотлох баримт болох нь, УБ., 2006.
11. Батзориг.Б., Баясгаланбат.Н., Гантулга.С., Ичинхорлоо.С., Лхагвамаа.Г. Хүн худалдаалах гэмт хэрэг, УБ., 2009.
12. Батхуяг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, УБ.,2008,
13. Бат-Эрдэнэ.Б., Нямдаваа.О., БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй 1-р дэвтэр, ерөнхий анги, УБ., 1987.
14. Бат-Эрдэнэ.Б., Нямдаваа.О., БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй 2-р дэвтэр, Урьдчилсан мөрдөн байцаалт, УБ., 1987.
15. Бат-Эрдэнэ.Б., Нямдаваа.О., БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй 3-р дэвтэр, Шүүн таслах ажиллагаа, УБ., 1988.
16. Бат-Эрдэнэ.Б., Байцаалт түүний онцлог, УБ., 1994.
17. Бат-Эрдэнэ.Б., Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй (альбом схем) УБ., 2009.
18. Болдбаатар.Ж., Илрээгүй гэмт хэргийг илрүүлэх ажиллагаа, УБ., 1999.
19. Болдбаатар.Ж., Болдбаатар.Б., Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийг нотлох ажиллагаа, УБ., 2004.
20. Билгүүн.З, Хатанбаатар.М, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, УБ.,2009.
21. Буд.С, Зүмбэрэлхам.Д, Пүрэвням.Б, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх зүйн байдал, УБ.,2006.



22. БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, ред, Г.Совд, УБ., 1987.
23. Бүдрагчаа С., Комиссаров.В.И., Урьдчилсан мөрдөн байцаалтын шинжлэх ухааны үндэс, УБ., 1987.
24. Бүдханд.Ц., Криминалистик, УБ., 2002.
25. Бямбаа.Ж., Баясгалан.Г., Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд (ерөнхий анги) УБ., 1999.
26. Бямбаа.Ж., Мөнхжаргал.Т., Нарангэрэл.С., Совд.Г., Уранцэцэг.Г., Амарсанаа.Ж., Баясгалан.Г., Хууль зүйн тайлбар толь, УБ., 2003.
27. Бямбаа.Ж., Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд, УБ., 2008.
28. Галдаа Б., Монгол Улсын нотолгооны эрх зүйн үндсэн асуудал, УБ., 2001.
29. Ганбат.Э., Цэрэнбат.М., Шүүх эмнэлэг, УБ., 2005.
30. Ганболд.Э., Цэрэнбат.М., Шүүх эмнэлэг, УБ., 2005.
31. Гансүх.Ц., Наранбаатар.Г., Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох нь, УБ., 2005.
32. Глазырин.Ф.В., Мөрдөн байцаалтын сэтгэл зүй, УБ., 1987.
33. Гэмт хэргийн лавлах, Боть I, эмх, А.Чулаанбат, Б.Буянаа, УБ., 2004.
34. Гэмт хэргийн лавлах, Боть II, эмх, А.Чулаанбат, Б.Буянаа, УБ., 2004.
35. Гэрэлмаа.Т, Банзрагч.С, Захиргааны хэрэг, маргаан хянан шийдвэрлэх зарчим, УБ., 2005.
36. Довдон.Ш., Криминалистик /гарын мөр/, УБ., 2002.
37. Долгор.П. Монголын өмгөөлөгчдийн байгууллага ба өмгөөлөл, УБ., 2005.
38. Доржготов.А., Сонгино.Ч., Зурагт толь, УБ., 1998.
39. Дорждамба.Ш., Шүүхийн сэтгэц гэм судлал, УБ., 1990.
40. Доржпалам.Х., Сайнжаргал.Ж., Гэмт хэрэг илрүүлэх хойшлуулшгүй ажиллагаа, УБ., 1996.
41. Доржханд.М, Оросоо.Д, Лхамдарь.Д, Монгол улсын шүүхийн шийдвэрийн эмхтгэл –иргэний хэрэг, УБ., 2008.
42. Дугармаа.А., Доржготов.А., Баасан.Л., Мөнхжаргал.Т., Хуяг.Д., Улаанбаатар.Б., Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, ерөнхий анги, УБ., 1999.
43. Жанцан.Ё., Хэргийн газрын үзлэгээр эд мөрийн баримт олж, илрүүлэх ба бэхжүүлэх арга, УБ., 1971.
44. Жаргал.Б., Хишигтогтох.Б., Нотлох баримтын онолын үндэс, УБ.2002. Зүмбэрэллхам.Д., Мөрдөн байцаалтын туршилт, УБ., 1997
45. Зүмбэрэллхам.Д., Таньж олуулах ажиллагаа, УБ., 1994.
46. Зүмбэрэллхам.Д., Шүүхийн мэтгэлцээн, УБ., 2002.
47. Зүмбэрэллхам.Д., Өмгөөлөгчийн мэтгэлцэх ур чадвар, УБ., 2002.
48. Зүмбэрэллхам.Д., Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй дэх гэм буруугүйн презумпци, УБ., 2005.

49. Лүндээжанцан.Д., Жамбажав.Н., Отгонтуяа.Д., Эрх зүйн философи, УБ., 1998.
50. Монгол улсын захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /шүүгчдэд зориулсан гарын авлага, /Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Эрх зүй боловсрол, академи, УБ., 2005.
51. Мөнхжаргал.Т, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй /ерөнхий анги/, УБ.,2009.
52. Мөнхжаргал.Т, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй /тусгай анги/, УБ.,2010.
53. Мөнхжаргал.Т, Монгол Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, УБ.,2009.
54. Мөнхжаргал.Т, Арбитрын процессын эрх зүй, УБ.,2008.
55. Мөнхжаргал.Т Ред, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй: Тусгай анги, УБ.,2006.
56. Мөнхжаргал.Т, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй: Ерөнхий анги, УБ.,2008.
57. Оюунчимэг.Т., Мөрдөн байцаалтын практикаас (Цуврал –1) УБ., 1999.
58. Оюунчимэг.Т., Мөрдөн байцаалтын практикаас (Цуврал –2) УБ., 2001.
59. Нарангэрэл.С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, УБ., 2001.
60. Нарангэрэл.С., Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс, УБ., 1988.
61. Нарангэрэл.С. Амьд эрх зүй, УБ., 2002.
62. Наранцацрал.Ж, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, УБ.,2007.
63. Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл /Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. УБ., 2012.
64. Оюунчимэг.Т., Мөрдөн байцаалтын практикаас I, УБ., 2000.
65. Оюунчимэг.Т. Мөрдөн байцаалтын практикаас I, УБ., 2002.
66. Оюунчимэг.Ж., Баясгалан.Г., Цэрэнбалтав.Б., Прокурорын ном гарын авлага, УБ., 2003.
67. Прокурорын ном 2, ред., М.Алтанхуяг, УБ., 2003.
68. Туяа.Н., хамтын бүтээл, Прокурорын байгууллагын тухай хуулийн тайлбар, УБ., 2003.
69. Туяа.Н., Эрүүгийн байцаан шийтгэх албадлагын арга хэмжээ гарын авлага, УБ., 2007.
70. Туяа.Н., Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хялбаршуулсан тайлбар, УБ., 2010.
71. Тажебакед К., Даваадорж А., БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй дэх нотлох баримтын онол, УБ., 1989.
72. Халуун мөр, редактор Д.Алтангэрэл, УБ., 1996,
73. Хурцгэрэл.Ж., Криминалистик, УБ., 1987.



74. Хурцгэрэл.Ж., Криминалистик-1, УБ., 2002.
75. Хурцгэрэл.Ж., Криминалистик-2, УБ., 2003.
76. Хүний амины гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах аргачилал, УБ., 1984.
77. Хуульчийн ур чадвар сургалтын гарын авлага, УБ., 2007.
78. Чимэд.Б., Үндсэн хуулийн үзэл баримтлал /нийтлэг асуудал/, УБ., 2004.
79. Чулуунбат.Д., Зарим төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд анхаарах асуудал, УБ., 2001.
80. Чувилев.А.Н., Мөрдөн байцаалтын ажиллагаа, УБ., 1988.
81. Энхтуяа.А., Эрдэнэцогт.Н., Захиргааны эрх зүй, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн ойлголтууд, УБ., 2003.

### **Б. Гадаад хэлээр**

1. Белкин.А.С., Теория доказывания, М., 1999.
2. Владиморов.Л.Е., Учение об уголовных доказательствах, Тула, 2000.
3. Вопросы общей теории судебных доказательств, М., Юрид.лит, 1964.
4. Зажицкий.В.О., Допустимость доказательств //Российская юстиция, 1999., №3.
5. Кипнис.Н.М., Допустимость доказательств в уголовном судопроизводстве, М., 1995.
6. Основы теории судебных доказательств, М., 1960.
7. Строгович.М.С., Избранные труда, М., 1991.
8. Теория доказательств в Советском уголовном процессе. УБ., 1973.
9. Теория доказательств в советском уголовном процессе, Часть общая, От. Ред., Н.В.Жогин, М., 1966.
10. Шейфер.С.А., Сущность и способы собирания доказательств в советском уголовном процессе, М., 1972.
11. Ali Safak, Vahit Bigak. Ceza Muhakemesi Hukuku ve Polis. Ankara, 1999. (Турк хэлээр)
12. Freda Adler, Gerhard O.W.Mueller, Eilliam S.Laufer, Criminal justice, McGraw-Hill, 2000.
13. Feely, Malcolm M. The process is the Punishment: 1992.
14. Жан Вуй, Нотлох баримтын эрх зүй, 1999. (хятад хэлээр)
15. Тэнкушуи, Японы Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, 2000. (япон хэлээр)



## В. Докторын диссертаци

1. Ж.Хурцгэрэл, Малын мөр, тамганд хийх праслогийн шинжилгээ, Дэд эрдэмтэн, 1988 он
2. Д.Жаргалсайхан, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бодит үнэний зарчим, Дэд эрдэмтэн, 1991 он
3. Д.Зүмбэрэлхам, Монголын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй дэх гэм буруугүйд тооцох зарчмыг сахин хэрэгжүүлэх асуудал, /Ph.D./ 2001 он
4. Ж.Болдбаатар, Хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийн нотолгооны асуудал, /Ph.D./ 2003 он
5. Б.Бат-Эрдэнэ, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч шинжээчийн эрх зүйн байдал, /Ph.D./, 2009 он
6. Ц.Гантулга, Гэмт хэргийг илрүүлэхэд мөр нотолгооны ач холбогдолтой болох нь /амьтны мөрийн жишээн дээр/, /Ph.D./, 2009 он
7. Т.Оюунчимэг, Гүйцэтгэх ажлын үр дүнг Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд нотлох баримтаар ашиглах нь, /Ph.D./, 2009 он
8. П.Оюунчимэг, Эрүүдэн шүүлт ба хүний эрх, /Ph.D./, 2010 он
9. Л.Мөнхсайхан, Монгол Улсын шүүн таслах ажиллагааг талуудын эрх тэгш байдал, мэтгэлцээний үндсэн дээр явуулах зарчим, түүний эрх зүйн зохицуулалтын асуудлууд, /Ph.D./, 2011 он
10. Б.Батзориг, “Эрүүгийн нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагааны онол, практикийн асуудал”, /Ph.D./, 2012 он





# ХОЁР

## НОТОЛГООНЫ ОНОЛ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

### СЭДЭВ 1. НОТОЛГООНЫ ОНОЛ

**Сэдвийн зорилго:** *Нотолгооны онол хичээлийг судлах шаардлага, хэрэгцээг тодорхойлох, суурь мэдлэг олгоход чиглэгдэнэ.*

#### Нотолгооны онол хичээлийг судлах шаардлага, ач холбогдол

Нотолгоо нь бидний өдөр тутам хэрэглэгддэг танин мэдэхүйн үйл ажиллагааны нэгэн төрөл юм. Үүнд үндэслэн бодитой шийдвэр гаргах боломжтой болдог. Энэ нь зорилго чиглэлээсээ хамааран өөр өөр байдаг ч бүхнийг хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулах боломж ч, шаардлага ч тэр бүр байдаггүй.

Хүний энгийн амьдралаас шинжлэх ухааны нарийн ээдрээ төвөгтэй ажилд “нотлох, батлах” үйл явц тогтмол явагддаг.



#### Нотолгооны онцлог:

- Шинэ зүйлийг танин мэдэхэд чиглэгддэг;
- Аливаа маргаан, эргэлзээг арилгахад чиглэгддэг;
- Шинэ мэдлэг бүтээдэг;

#### Эрх зүйн зөрчлийн нотолгооны онцлог:

- Бусад нотолгооны хэлбэрийн аргыг өргөнөөр ашигладаг;
- Танин мэдэх арга хязгаарлагдмал, хуульчилсан;
- Баримт цуглуулах явцад хүний эрхэд хуулийн дагуу халддаг;
- Маргалдагч талууд цугларсан, цуглуулсан баримтад тулгуурлан мэтгэлцэнэ;
- Бодит үнэнийг шүүх тогтооно;

Эрх зүйн зөрчлийн нотолгоо нь гэмт хэргийн, иргэний, захиргааны, үндсэн хуулийн, арбитрын маргааныг зохицуулсан хууль тогтоомжийн онцлогоос хамааран ялгагддаг.

Эрх зүйн хэрэг маргааныг нотлоход чиглэгдсэн дараах үндсэн гурван загвар байсан.

## **Мэтгэлцүүлэн шүүх загвар (Litigant Adversary Doctrine)**

Мэтгэлцүүлэн шүүх загварын хянан шийдвэрлэх ажиллагааг ихэвчлэн Англо-Саксоны эрх зүйн бүлийн улсууд хэрэглэдэг. Яллах, өмгөөлөх ажиллагаа тус тусдаа явагдах бөгөөд шүүх талуудан мэтгэлцээнд тулгуурлан шийдвэр гаргадаг.

Мэтгэлцүүлэн шүүх загварын онцлог:

1. Мөрдөн шалгах шатанд сэжигтэн, яллагдагчдад нотлох баримт гаргах эрхийг өргөнөөр олгож, мөрдөн шалгах байгууллагын үйл ажиллагааг хуулиар ихээхэн хязгаарлан тогтоодог. Мөрдөн шалгах шатанд Англо-Саксоны эрх зүйн бүлийн улсууд сэжигтэн, яллагдагчид мэдүүлэг өгөхгүй байх болон өмгөөлөгч авах эрхийг олгосон байдаг. Энэ шатанд сэжигтэн, яллагдагч нь өөрийн хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалж оролцдог.
2. Яллах, өмгөөлөх талууд тэгш эрхтэйгээр яллах, цагаатгах, хөнгөрүүлэх, хүндрүүлэх нотлох баримт цуглуулж шүүхийн өмнө ил мэтгэлцэнэ.
3. Шүүх хуралдаанд шүүгч идэвхигүй хөндлөнгийн байр сууринаас оролцож, мэтгэлцэгч талууд идэвхитэйгээр оролцдог. Шүүгч нь талуудын гаргаж өгсөн нотлох баримт, мэтгэлцээнд тулгуурлан шийдвэр гаргадаг.

## **Мөрдөн шүүх загвар (EX office doctrine)**

Энэ загварыг голдуу Ром-Германы эрх зүйн бүлийн улсуудад хэрэглэдэг бөгөөд “шүүх, прокурор, мөрдөгч нь яллах болон цагаатгах, хүндрүүлэх болон цагаатгах нотлох баримтын аль алиныг нь цуглуулж, хэргийг бодит үнэлгээний зарчимд тулгуурласан хянан шийдвэрлэх ажиллагаа юм”.

Мөрдөн шүүх загварын гол онцлог:

1. Мөрдөн шалгах шатанд өмгөөлөх талын эрх хязгаарлагдмал, мөрдөн шалгах байгууллагын эрх мэдэл их байдаг.
2. Нотлох ажиллагааг мөрдөгч, шүүгч гардан хийдэг.
3. Шүүх хуралдаанд шүүгч үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог, мэтгэлцэгч талуудын эрх нь харьцангуй хязгаарлагдмал байдаг. Шүүх хуралдаанд шүүгч гол үүрэг гүйцэтгэж, нотлох баримт шалгах, үнэлэх зэрэг ажиллагааг бие даан идэвхитэйгээр явагдуулж, эрх мэдлийнхээ хүрээнд хэргийн нөхцөл байдлыг дотоод итгэлээрээ тогтоон шийдвэр гаргадаг.



Мөрдөн шүүх загвар бүхий улсын мөрдөн шалгах байгууллага болон өмгөөлөх талын эрх, үүрэг тэгш биш. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгч харьцангуй сул эрхтэй, тэд нотлох ажиллагаанд оролцоо багатай.

Шүүгч нь шүүх хурал эхлэхээс өмнө мөрдөн шалгах ажиллагааны шатанд бүрдчихсэн нотлох баримтанд тулгуурлан дотоод итгэл үнэмшилтэй болдог. Иймээс онцгой шинэ нотлох баримт өмгөөлөгч талаас гаргахгүй л бол шүүгч өөртөө нэгэнт бий болсон дотоод итгэл үнэмшлээрээ шийдвэрлэх хандлагатай байдаг.

### **Холимог загвар**

Холимог загвар нь яллах болон эрэн сурвалжлах загварын онцлогуудыг багтаасан байдаг. Мөрдөн шалгах ажиллагаанд шатанд яллагдагч, түүний өмгөөлөгчийн эрхийг зарим талаар хязгаарладаг, хэрэг бүртгэгч, мөрдөгч хэргийг мөрдөн шалгахын зэрэгцээ хэргийн талаар тодорхой шийдвэр гаргадаг, хэргийн бодит үнэнийг тогтоох зарчмын хүрээнд ЭБШ ажиллагааг хэрэгжүүлэгчид цагаатгах болон яллах, нотлох баримтын аль алиныг нь цуглуулдаг хувилбар юм.

Холимог загварын онцлог:

1. Нотлох үүргийг мөрдөгч, эсхүл прокурор хүлээдэг.
2. Мөрдөн шалгах, шүүн таслах чиг үүргийг өөр өөр субъектуудэд хариуцуулсан.
3. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг урьдаас гэмт хэрэг үйлдсэн, гэм буруугүй гэж үзэж хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах зарчмыг (doctrine of the presumption of innocence) хэрэгжүүлнэ.
4. Нотлох баримтыг шүүгч өөрийн дотоод итгэлээр үнэлдэг.

Холимог хэлбэрийн хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхээс өмнөх мөрдөн шалгах үе шат болон шүүх хуралдааны үе шат гэж хоёр хуваадаг. Мөрдөн шалгах байгууллага нь шүүхээс хараат байж, мөрдөн шалгах шатанд шийдвэрлэх асуудал нь шүүхээс хамааралгүй байдаг.

Холимог загвар нь мэтгэлцүүлэн шүүх, болон мөрдөн шүүх загварын аль нь давамгайлж байгаагаас шалтгаан онцлог шинж нь өөр өөрөөр илэрдэг.

## СЭДЭВ 2. НОТОЛГООНЫ ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ

**Сэдвийн зорилго:** *Нотолгооны тухай онолын төдийгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрхэн хэрэглэж болох ур чадвар олгоход чиглэгдэнэ.*

**Нотолгоо** гэдэг нь хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгасан шийдвэр гаргахын тулд тодорхой этгээдээс нотолгооны зүйлийг гэмт хэргийн бүрэлдэхүүн болон түүнтэй холбогдон бий болох бусад нөхцөл байдлуудыг албан ёсны цогц нотлох баримтаар тогтоох танин мэдэхүйн цогцолбор үйл явцыг хэлнэ.

Нотолгоо нь дараах шинжтэй:

- Зорилго, чиглэлтэй үйл ажиллагаа;
- Өөрийн гэсэн танин мэдэхүйн өвөрмөц аргатай;
- Тодорхой үе шат, явагдах дэс дараалалтай;
- Цаг хугацаа, орон зай, үйл ажиллагааны тодорхой хэмжээ, хязгаартай;
- Хэн дуртай нь бус тодорхой чадвар бүхий этгээдээс хэрэгжүүлдэг;
- Буруу хэрэгжүүлбэл эрх зүйн болон нийгмийн сөрөг үр дагаврыг дагуулдаг;
- Дээрх үйл ажиллагааг хуульчлан зохицуулах шаардлагатай;

Эрх зүйн хэрэг маргааныг нотлох ажиллагаа нь (эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, иргэний эрх зүй, захиргааны эрх зүй, арбитра, олон улсын эрх зүйн гэх мэт) танин мэдэхүйн үйл явцын хамгийн ээдрээ төвөгтэй асуудлын нэг төдийгүй ертөнцийг танин мэдэх үйл ажиллагааны нэг хэсэг болж түүний ерөнхий шинжийг илэрхийлэхийн хамтаар хуульд заасан нөхцөлөөс хамаарч өөрийн гэсэн онцлогтой. Тиймээс үүнийг хуулиар зохицуулж нэгэн мөр болгох, улам боловсронгуй болгож байхыг нийгэм шаарддаг.

Эрх зүйн зөрчил, маргааны ул мөр буюу мэдээлэл нь хүний мэдрэхүйн эрхтэн, сэтгэхүйгээр дамжиж ямар нэг байдлаар мэдэрч хүний ой ухаанд түүнчлэн тэдний хадгалж байгаа эд зүйл, бичиг баримтад болон материаллаг ертөнцөд ямар нэг хэлбэрээр үлддэг.

Аливаа үйл ажиллагаа нь өөрийн гэсэн зорилготой байдаг. Зорилго нь тодорхой, хүрэхүйц бодитой байх хэрэгтэй, зорилго нь тоогоор илэрхийлэгдэхээс гадна цаг хугацаагаар хэмжигддэг, түүнчлэн хүрэх гэж буй бодит үр дүн байдаг. Бодит үнэнийг тогтоох нь гэмт хэргийн нотолгооны зорилго байдаг.

Хуульд заасан тодорхой нөхцөл байдлыг тогтооход нотолгоо заавал явагдах ёстой. Нөхцөл байдлыг тогтоосон баримт сэлт мэдээлэл үнэн бодитой, хууль



ёсны, үнэмшилтэй байж л шийдвэрийн үндэслэл болдог. Шийдвэр гаргахад нөлөөлдөггүй үнэн гэж байж болохгүй.

Үнэн гэдэг ойлголт нь өөрөө хийсвэр, логик шинжтэй учир түүнийг бодитойгоор илэрхийлэх боломж байхгүй боловч нотолгооны зорилго нь хуульд заасан тодорхой үндэслэл бүхий шийдвэрээр илрэн гардаг. Энэхүү шийдвэр нь бодитойгоор оршихоос гадна түүнийг хэмжих, тодорхойлох боломжтой.

Нотолгооны зорилго болсон хэргийн бодит үнэн гэдэг бол тухайн үед үйлчилж байсан хуулийн хүрээнд танин мэдэхүйн тодорхой аргуудын хүрээнд үүрэг бүхий албан тушаалтны зүгээс цуглуулсан нотлох баримтад тулгуурласан үнэн юм. Энэхүү үнэнд ямар нэг эргэлзээ төрөх ёсгүй. Хэрэв эргэлзээ төрвөл ялангуяа, гэмт хэрэг үйлдсэн хүнд ашигтайгаар шийдвэрлэдэг.

Болж өнгөрсөн бодит үйл явдлыг зөвөөр тогтоож чадаагүй, нэг талыг барьсан буюу эсхүл мөрдөх ажиллагааг гүйцэд явуулаагүй бол бодит үнэнийг дахин тогтоох шаардлага аяндаа гарч ирнэ. Өөрөөр хэлбэл, цугларсан нотлох баримт нь туйлын үнэн биш бөгөөд цаг хугацааны явцад гадны ямар нэг нөлөө хүчин зүйлээс хамаарч нотлох баримт хуурамч гэдэг нь хуулийн дагуу нотлогдвол тэр нь хэргийг сэргээх үндэслэл болно.

Гэхдээ энэхүү үнэн нь туйлын бус харьцангуй бодит үнэн юм. Харьцангуй үнэн гэдэг нь юмс үзэгдлийн мөн чанарын зарим хэсгийг мөн ерөнхий чанарыг танин мэдсэн үнэн, тэгэхдээ тухайн үеийн хэмжээнд л хүрсэн үнэн мэдлэг, цаашид улам гүнзгий судлах замаар төгс боловсронгуй болж байх ёстой мэдлэг тул бодит үнэнг хүн харьцангуй үнэний замаар ойртож илрүүлэх ба нэг мөсөн илрүүлэх боломж хязгаарлагдмал. Эдгээр нь зөвхөн хуульд заасан үндэслэл журам, аргаар авагдсан баримт, сэлтийн тухайд яригдана. Харин гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа болон хохирсон этгээдүүдийн хувьд үнэн нь туйлын байж болно. Учир нь тухайн этгээдийг тогтоох гэж буй нөхцөл байдлыг өөр өөрсдийнхөөрөө мэдэрч үнэлсэн байдаг.

Хэрэг маргааны нотолгоо нь үнэн, эсхүл худал гэсэн хариулттай. Энэ хоёр зэрэгцэн оршихгүй, түүнчлэн гуравдагч гарц байхгүй. Үнэн нь дараах шинжтэй.


- Туйлын ба харьцангуй шинжийг давхар агуулж байдаг;
- Нотолгооны бодит үнэнг тогтоох үйл явц нь гагцхүү хүчин төгөлдөр Монгол улсын хуулийн хүрээгээр хязгаарлагдана;
- Бодит үнэн нь нотолгооны зорилго бөгөөд зөвхөн хуульд заасан тодорхой шийдвэр гаргахад чиглэгдсэн байна;
- Бодит үнэнг гагцхүү хуулийн дагуу олж авсан нотлох баримтад тулгуурласан байна;
- Хэргийн нөхцөл байдлын талаар үгүйсгэсэн, нотолсон боломж хоёулаа нэгэн зэрэг үнэн байж болохгүй;
- Бодит үнэнийг тогтоох үйл ажиллагаа хуулиар тогтоосон хөөн хэлэлцэх хугацааны дотор хийгддэг;

- Үндсэн хууль болон бусад хуулийн дагуу байгуулагдсан шүүх хуулийн дагуу бодит үнэнийг эцэслэн тогтооно;
- Бодит үнэнийг олонхийн саналаар шийдэх бөгөөд зөвхөн эрх зүйн үнэлгээ байдаг. Энэ нь баримтад тулгуурласан байна;
- Тогтоогдсон бодит үнэн нь үгүйсгэсэн буюу шинээр илэрсэн нөхцөл байдал илрэх хүртэл нь орших буюу үндэслэл бүхий шүүхийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоол болон бусад шийдвэрээр үгүйсгэгдэнэ;
- Бодит үнэнийг тогтоосон арга нь ил, буюу далд байх боловч энэ нь тодорхой, шинжлэх ухаанаар нотлогдож нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байх бөгөөд энэрэнгүй, хүний ёсонд нийцсэн байна;
- Бодит үнэн нь зөвхөн тухайн нотлох гэж байгаа үйл явдалд л хамааралтай байна;
- Тогтоосон бодит үнэнг практик үйл ажиллагаагаар баталж шалгах боломж хязгаарлагдмал байдаг.

## Хэрэг маргааны нотолгооны зорилт:

- Нийгэмд шударга ёсыг төлөвшүүлэх,
- Хууль ёсыг хангаж тодорхой шийдвэр гаргах,
- Иргэдэд хууль хүндэтгэх үзэл төлөвшүүлэх,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх,
- Хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа хүн, байгууллагын хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах,
- Нийгэмд үүссэн зарим бухамдлыг арилгах,
- Хууль тогтоомжийг боловсронгуй болгох.

## НОТОЛГООНЫ ТӨРӨЛ



**Нийтийн нотолгоо** гэдэг нь хууль сахиулагчид хуульд заасан үндэслэл журмын дагуу гэмт хэргийн бодит үнэнийг тогтооход чиглэгдсэн үйл ажиллагаа

**Хувийн нотолгоо** гэдэг нь хуулиар нотлох үүрэг хүлээгээгүй субъектийн зүгээс гэмт хэргийн бодит үнэнийг тогтооход чиглэгдсэн үйл ажиллагаа



### **Нийтийн нотолгоо, хувийн нотолгоо хоёрын ялгаатай тал:**

1. Нийтийн нотолгоог хуулиар үүрэг болгосон хууль сахиулагч хэрэгжүүлдэг бол хувийн нотолгоог сонирхогч хүмүүсээс явуулж болдог;
2. Нийтийн нотолгоог хэрэгжүүлж буй хүмүүсийн үйл ажиллагаа хуулиар хязгаарлагддаг бол хувийн нотолгоог хэрэгжүүлж буй этгээдүүдийн үйл ажиллагааг хуулиар нарийвчлан зохицуулаагүй байдаг;
3. Нийтийн нотолгоо нь хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд эхлэн явдаг бол хувийн нотолгоог сонирхогч этгээд өөрийнхөө хүсэл зориг, санаа бодлоос хамааран эхлэн явуулдаг;
4. Нийтийн нотолгоо нь хуульд заасан хугацааны дотор хэрэгждэг бол хувийн нотолгооны хугацаа сонирхогч этгээдийн хүсэл зоригоос шууд шалтгаална;
5. Нийтийн нотолгоо нь төр, Үндсэн хуулиар иргэнийхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаагийн илрэл байдаг бол хувийн нотолгоо нь өөрийн болон сонирхогч этгээдийн хүсэл зоригийг хамгаалахад чиглэгдсэн байдаг;
6. Нийтийн нотолгооны явцад цугларсан нотлох баримт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэрт шууд нөлөөлж байдаг бол хувийн нотолгоогоор цугларсан нотлох баримт нь шийдвэрт нөлөөлөх хүчин чадалгүй, заавал төрийн нотолгоогоор дамжин баталгааждаг.

### **ДАСГАЛ АЖИЛ:**

1. Дараах хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаан дах төрийн болон хувийн нотолгооны онцлогийг тодорхойлж, төрийн болон хувийн нотолгоог харьцуулна уу.
  - гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа,
  - иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа,
  - захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа,
  - үндсэн хуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа,
  - арбитрын маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа.
2. *Эртний үлгэрээс:* Хааны өмнө нэгэн хүүхдийн эх хэмээн хоёр эмэгтэй заргалдан иржээ. Хаан хэсэг бодолхийлснээ сэлэм аван хүүхдийг цавчих гэтэл нэг эмэгтэй нь зүгээр зогсож, харин нөгөө эмэгтэй нь хүүхдийг аврахаар ухасхийн тэвэрч авчээ. Хаан тэр эмэгтэйд эх хэмээн тооцож нөгөө эмэгтэйд шийтгэл хүлээлгэжээ.

Хаан асуудалд хэрхэн хандсан бэ? Нотолгооны үнэний талаар харилцан ярилцана уу?



## СЭДЭВ 3. НОТОЛГООНЫ АРГА, ҮЕ ШАТ

**Сэдвийн зорилго:** *Нотолгооны явцад ямар аргыг хэрхэн хэрэглэж болох, аливаа хэрэг маргааныг нотлох нийтлэг үе шатны талаар мэдлэгтэй болох, танин мэдэхүйн сэтгэлгээний аргыг ашиглан цэгцтэйгээр нотлох гэж буй үйл явцыг таних тэдэх, түүнийг бүтээлчээр хэрэглэх чадвар хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.*

### Нотолгооны түгээмэл арга

**Нотолгооны түгээмэл** арга гэдэг нь нотолгооны онолын судлах зүйлийг танин мэдэх тодорхой үйл явцын бүх үе шат болон аливаа шинжлэх ухааны салбарын судалгааны явцад эрдэмтэн судлаачдын удирдлага болгодог горим журам юм.

Түгээмэл аргын хамгийн анхдагч буюу эртнийх нь диалектик, метафизик арга. Цаашилбал, аргын хүрээнд: задлан шинжлэх (анализ), зөн совин (интуици), өвөрмөц үзэгдлийг судлах (феноменологи), хийсвэрлэх аргууд, тайлбарлах, ойлгох (герменевтик), бүтэцлэх, хуурмаглах (фальсификаци), олончлох (плюралист), нэгтгэх (интегратив), хэрэглээ, ашиглах (прагматив), жишин харьцуулах (компаратив) аргуудыг багтааж болно. Арга нь шинэ мэдлэг, онолыг бүтээхийн тулд хэрэглэдэг учир ямар ч мэдлэг нэг талаас шинжлэх ухааны танин мэдэхүйн үр дүн, нөгөө талаас шинэ мэдлэгт хүрэх хэрэгсэл болдог.

### Сэтгэлгээний нийтлэг арга

Хэргийг бодит байдлаар нь нотолж тогтооно гэдэг нь зөвхөн нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэхээр хязгаарлах бус сэтгэхүйн асар нарийн үйл ажиллагаа явагдаж байдаг.

Хэргийг нотлоход **сэтгэхүйн аргууд** болох анализ, синтез, индукци, логик зэрэг аргуудыг хэрэглэх нь үр дүнтэй. Эдгээрийн тусламжтайгаар ургуулан бодож дүгнэлт гарган нотолгооны субъектүүд тодорхой шийдвэрт хүрдэг. Өөрөөр хэлбэл, нотолгооны явцад бий болсон бүх шийдвэр үр дүн нь (мөрдөгч, шүүхийн шийдвэр, цугларсан нотлох баримт гэх мэт) танин мэдэх сэтгэхүйн аргын тусламжтайгаар бий болдог гэсэн үг юм.

Сэтгэхүйн аргуудыг нотолгооны бүх үе шатуудад хийгддэг бөгөөд түүнийг явуулах хатуу тогтоосон журам байдаггүй. Энэ нь ямар нэг эд зүйл, мэдүүлэгт дүгнэлт өгөхөөс бүх нөхцөл байдлыг үнэлэхэд чиглэгдэнэ. Сэтгэхүйн аргыг хэдий оновчтой, сайн ашиглана төдий хэмжээгээр бодит үнэнд хүрэх арга зам илүү оновчтой, үндэслэгээ нотолгоо нь бодитой, үнэмшилтэй байна.





Сэтгэлгээний нийтлэг арга нь дараах онцлог шинжтэй. Үүнд:

Нотолгоог зөв дэс дараалалтайгаар, зөрчилдөөнгүй явуулж улмаар нотлох баримтыг зохих шийдвэр гаргахад нөлөөлөх чадвар, хамаарах байдлаар нь ангилахад чиглэнэ. Учирч болох бүх хүндрэл, гарах арга замыг урьдаас бодож олсон байх ёстой.

Сэтгэлгээний аргыг хэрэглэх үр чадварыг амьдралын туршлагаас олж авдаг. Түүнчлэн боловсрол, мэргэжил, мэргэшлийн сургуулиас сэтгэхүйн онцлог аргуудыг зохих дэс дараалалтай, зөв хэрэглэж сурах аргыг олгодог.

Цугларсан бүх нотлох баримтууд бүтээлч сэтгэлгээний үр дүн мөн. Сэтгэлгээний арга нь оюуны хөдөлмөр учир тухайн аргыг хэрэглэж байгаа эсэхийг зөвхөн үр дүнгээр тооцоолно.

Сэтгэлгээний явцад бий болсон үр дүн нь нотлогдохгүй бол түүнийг шийдвэр гаргахад ашиглаж болохгүй.

Сэтгэлгээний нийтлэг аргыг нотолгооны туршид байнга хэрэглэнэ.

**Анализийн арга.** Цугларсан нотлох баримтад үндэслэн болж өнгөрсөн үйл явцыг задлан, цаашид хэрхэхийг шийдвэрлэдэг арга юм.

**Синтезийн арга** нь нотлох баримтад тулгуурлан нэгдсэн ойлголтод хүрэхэд чиглэгддэг.

Баримт сэлт, мэдээллийг нэг бүрчлэн судалж байгаа аргыг **индукцийн арга** гэнэ.

Гэмт хэргийн нотолгоо нь цугларсан мэдээлэл дээрээ үндэслэн таамаглал дэвшүүлэн түүнийг шалгах замаар явагддаг. Энэ аргыг **гипотезийн арга** гэнэ.

**Хийсвэрээс бодит байдалд шилжих арга.** Нотолгооны субъект нь хийх зүйлээ хийсвэрлэн бодож улмаар түүнийгээ бодит байдалд шилжүүлэн ажил хэрэг болгож байгаа арга юм.

**Логик арга.** Баримт сэлт мэдээллүүдийн дотоод мөн чанар, зүй тоглыг нээн илрүүлж тогтоох гэж буй үзэгдэл үйл явцын уялдаа холбоо бодит байдлыг тогтоож байгаа арга юм.

**Харьцуулалтын арга.** Гэмт хэргийг нотолж байсан практик үйл ажиллагаан дээр дүгнэлт хийж байгаа арга. Өөрөөр хэлбэл урд хийгдэж байсан гэмт хэргийн нотолгоог одоогийн ажиллагаатай харьцуулан практикт хэрэглэж болох эсэх, нотлох баримт болон тэдгээрийн эх сурвалжийн нийтлэг болон ялгаатай шинжээр харьцуулан дүгнэлт хийх арга юм.

**Системчлэх арга.** Цугларсан нотлох баримтуудыг нотолгооны зүйл, хэрэгт хамааралтай байдал болон бусад нийтлэг байдлаар нь ангилж эмх цэгцтэй болгон дүгнэлт хийхэд бэлэн болгоход чиглэгддэг арга юм.

Дээрх аргын тусламжтайгаар болж өнгөрсөн үйл явдал, нотлох баримт, тэдгээрийн эх сурвалж, мэдээллүүдийн хоорондын логик уялдаа холбоог гаргаж цааш ямар ажиллагаа явуулах, тэдгээрийн тактикийн болон мөрдөх

ажиллагааны тодорхой шийдвэр гаргахад хэрхэн ашиглаж болох талаар дүгнэлт гаргахад чиглэгддэг.

Нотолгооны тусгай аргуудыг хэрхэн зөв хослуулах нь сэтгэхүйн аргаас ихээхэн шалтгаалдаг.

## Нотолгооны тусгай арга.

Тодорхой хэргийг болон тэдгээртэй холбоотой бусад нөхцөл байдлыг тогтооход чиглэгдсэн аргуудыг тусгай арга гэнэ.

Нотолгооны  
уламжлалт арга

Нотолгооны  
уламжлалт бус арга

Олон жилийн туршид уламжлагдан хэрэглэж ирсэн аргыг **уламжлалт арга** гэнэ.

Нотолгооны уламжлалт арга нь:

- мөр хөөх,
- өчиг мэдүүлэг авах,
- нүүрэлдүүлэх,
- зургаар болон бусад байдлаар дүрслэн үзүүлэх,
- мэдүүлгийг газар дээр нь шалгах,
- үзлэг, нэгжлэг хийх,
- тусгай мэргэжлийн хүний тусламж авах,
- шинжилгээ хийлгэх,
- таньж олуулах,
- нууцаар мөрдөн тагнах,
- хэргийн газрыг шинжлэх зэрэг аргуудыг нэрлэж болно.

Эдгээр аргуудын дотор өнөөгийн практикт өргөн хэрэглэгдэж байгаа хуулиар зөвшөөрсөн арга байхад хүлээн зөвшөөрөгдөөгүй, эрүүгийн хуульд гэмт хэрэгт тооцогдохоор аргууд байдаг. Үүнд, ямар нэг байдлаар эрх чөлөөг нь хязгаарлах /хорьж, цагдан хэрэг хүлээлгэх/, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, гутаан доромжлох, өлсгөх, ядраах, шахалт, дарамт үзүүлэх гэх мэт цаг үе, нийгмийн шаардлагаар хэрэглэгдэхээ больсон буюу соёлт ертөнцөд хуулиар хориглосон аргыг багтаан үзэж судалдаг.

Шинжлэх ухаан техникийн сүүлийн үеийн ололт амжилтад тулгуурласан урьд хэрэглэж байгаагүй буюу хязгаарлагдмал хүрээнд хэрэглэж байсан шинэ болон шинэлэг аргуудыг **уламжлалт бус арга** гэнэ.



Уламжлалт бус арга нь:

- сэтгэл зүйн сорилгын арга,
- цахим бичлэгийн арга,
- гипнозын буюу ховсдох арга,
- биологийн давтамж судлалын арга,
- бичгийн хэлбэрийн арга,
- хөгжмийн “дэвсгэр”-ийн арга,
- үнэрийн “талбай” ашиглах зэрэг нь шинжлэх ухаан технологийн сүүлийн үеийн ололт амжилтыг ашигласан бусад олон арга байдаг.

Нотолгооны арга түүхэн үүргээ гүйцэтгэн цаг хугацааны явцад өөрчлөгдөж шинэ шинэ арга бий болж байдаг.

Нотолгооны ямар ч арга өөрийн гэсэн сул болон давуу талтай учир тухайн нотлох гэж буй асуудлын онцлог байдлыг зөв уялдуулан, оновчтой хослуулан хэрэглэх нь нотолгооны зорилгыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

### **Нотолгооны үе шат**

Нотолгоо нь дараах үе шатыг дамжина:

- Хэрэг маргаан болон түүнтэй холбоотой бусад асуудлын талаарх мэдээлэл ирэх буюу тодорхой асуудлыг шийдвэрлэх шаардлага бий болох,
- Сэжүүр гаргах,
- Сэжүүр, таамаглалаа шалгах,
- Баримт цуглуулж, бэхжүүлэх,
- Мэтгэлцэх,
- Нотолгооны үр дүнг үнэлж шийдвэр гаргах

**Хэрэг маргаан болон түүнтэй холбоотой бусад асуудлын талаарх мэдээлэл ирэх буюу тодорхой асуудлыг шийдвэрлэх шаардлага бий болох.** Гэмт хэрэг үйлдэгдсэн гэсэн мэдээлэл ирэх эсхүл хуулиар хамгаалагдсан эрх зөрчигдсөн гэж үзэх.

**Сэжүүр гаргах.** Цугларсан нотлох баримтад үндэслэн анхан шатны сэжүүр гаргаж, таамаглал дэвшүүлнэ.

**Сэжүүр, таамаглалаа шалгах.** Дэвшүүлсэн сэжүүр, таамаглалаа бататгах буюу үгүйсгэх нотлох баримтуудыг цуглуулж бэхжүүлж, тэдгээрийг нотлох чадвар, тухайн асуудалд хамааралтай эсэхээр нь багц болгон шалгана. Хэрэв сэжүүр, таамаглал батлагдахгүй бол дахин нотлох баримт цуглуулах буюу цугларсан нотлох баримтад үндэслэн дараагийн шинэ сэжүүр, таамаглал дэвшүүлнэ. Сэжүүр, таамаглал батлагдвал дараагийн шат руу орно. Дэвшүүлсэн сэжүүр, таамаглал заавал батлагдаж байх албагүй. Энэ хэргийн нотолгооны хэмжээ, хязгаараас ихээхэн шалтгаалдаг.

**Баримт цуглуулж, бэхжүүлэх.** Энэ үе шатанд зөвхөн ямар нэг хэрэг учрал болсон гэх анхан шатны мэдээлэл байгаа учир шууд сэжүүр дэвшүүлэх

боломжгүй. Хэрэв энэ шатанд сэжүүр, таамаглал дэвшүүлэн түүндээ хөтлөгдвөл ноцтой алдаанд хүрч болно. Өөрөөр хэлбэл, энэ шатанд сэжүүр, таамаглал дэвшүүлэхэд хангалттай нотлох баримт цуглуулж бэхжүүлнэ гэсэн үг. Энэ үе шатанд цугларсан нотлох баримтуудыг нэгтгэн ангилах ажил мөн адил хамрагдана. Цуглуулсан бүх баримтаа бичгээр эсхүл техник хэрэгслийн туслалжтайгаар буулган бэхжүүлнэ. Бэхжигдээгүй баримт нотлох чадваргүй байдаг.

**Мэтгэлцэх.** Талуудын цуглуулж бэхжүүлсэн баримтыг хуульд заасан журмаар шинжлэн судалж, мэтгэлцэнэ.

**Нотолгооны үр дүнг үнэлж шийдвэр гаргах.** Талуудын мэтгэлцээний үр дүнд бий болсон нотлох баримтыг хуульд заасан шийдвэрийн үндэслэл болгоно. Шийдвэрийн үндэслэл болж буй асуудал нь бусад нотлох баримтаар үгүйсгэгдвэл нотолгоо дахин давтан явагдана. Эсхүл тухайн шийдвэрийг хүчингүй болдог.

Бүх үе шатуудад хэргийн нотолгооны сэтгэлгээний аргуудыг хэрэглэн хоорондын холбоо болон үе шатуудыг давтан хийх эсэхийг шийдвэрлэдэг.

Нотолгоо нь ямарваа нэг асуудлыг нотолж буруутгах буюу зөвтгөхийн тулд хийгддэггүй, харин тодорхой шийдвэр гаргахад чиглэгддэг учир нотлох үе шатанд оролцогчид харилцан тэгш эрхтэй байх ёстой.

Гэмт хэрэг үйлдэгдсэн гэх мэдээлэл бий болох, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх хүсэлт тавьсан үеэс хэргийн нотолгоо эхэлдэг. Энэ тохиолдолд тухайн үйлдэл, үйл явдал нь хууль зөрчсөн эсэхийг тогтоохын хажуугаар буруутай хүн, хуулийн этгээдийг олж тогтоох гэдэг нь хамгийн гол асуудал.

## ДАСГАЛ АЖИЛ:

1. Олны дунд нэр нь түгсэн нэгэн хэргийн талаар сонинд сайн, муу олон янзаар бичжээ. Нэгэн судалгааны байгууллага Б-г буруутай эсэх талаар ард иргэдийн дунд санал асуулга авчээ. Санал асуулгад оролцсон нийт хүмүүсийн 55 хувь нь түүнийг буруутай, ажлаасаа сайн дураараа халагдах ёстой. 30 хувь нь огт буруугүй, сөрөг тал нэр хүндээ өсгөх арга хэмжээ авч байгаа юм, буруугүй учраас ажлаасаа халагдах ёсгүй. 10 хувь нь энэ асуудлыг би сайн мэдэхгүй, 5 хувь нь энэ асуудал надад огт хамаагүй хэмээн хариулжээ.

Нотолгоог ийм аргаар явуулж болох уу? Яагаад? Судалгааны дүнг үндэслэн шийдвэр гаргаж болох уу? Хэрэв үүнийг үндэслэн Б-г ажлаас нь халсан бол хууль зүйн ямар үр дагавар үүсэх вэ?

2. Хэрэг маргааны нотолгооны аргууд нь эрх зүйн ямар зөрчлийн маргаан хянан шийдвэрлэж байгаагаас хамааран хэрхэн өөрчлөгдөж байгааг холбогдох хууль тогтоомж судлан үнэлэлт дүгнэлт өгнө үү.



## СЭДЭВ 4. НОТОЛГООНЫ ЗҮЙЛ, ХЭМЖЭЭ, ХЯЗГААР

**Сэдвийн зорилго:** *Аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ямар асуудлыг тогтоохын тулд ямар цаф хүрээгээр хиф хэтжээний баримтад тулгуурлах мэдлэгийг олж авах, түүнийг тухайн нөхцөл байдалд тулгуурлан оновчтой тодорхойлох хандлага төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.*

### Нотолгооны зүйл

**Нотолгооны зүйл** гэдэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тодорхойшийдвэргаргахынтулдзаавалнотлохбаримтынтусламжтайгаар тогтоогдсон байвал зохих нөхцөл байдлуудын логик уялдаа холбооны цогц юм.

Нотолгооны зүйлийг зөв тодорхойлсноор

1. Шүүн таслах ажиллагаа хэвийн явагдах нөхцөл байдлыг хангах;
2. Хэргийн нөхцөл байдлыг үнэн бодитой тогтоох урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэх;
3. Зөв зүйлчлэх, гэм бурууг тогтоож;
4. Шударга шийдвэр, хариуцлагахүлээлгэх;
5. Шударга ёсны баталгаа болдог.

Хэрэг бүрийн онцлог, шинж байдлаас нотолгооны зүйл шалтгаалах тул бүх хэрэг, маргаанд тохирох нотлогдвол зохих байдлуудын бүрэн жагсаалтыг хуульчлах боломжгүй.

Нотолгооны зүйлийг гагцхүү процессийн хуулиар тогтоох бус материаллаг хуулиар тодорхойлдог.

Нотолгооны зүйл нь хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны ямар шийдвэр гарахад нөлөөлж байгаагаас хамааран өөр өөр байх төдийгүй тухайн шийдвэрт шууд нөлөөлөхгүй туслах чанарын бусад нотлогдвол зохих байдлууд байдаг.



Гэрч А нь, тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нотлох гол гэрч. Гэтэл түүнийг нилээд худлаа ярьчихдаг гэсэн гэрч Б-гийн мэдүүлэг байна. Энд гэмт хэрэг үйлдэгдсэн гэдгийг А-ийн нотолж байгаа асуудал нь үндсэн нотолгооны зүйл. А худал мэдүүлэг өгсөн байх болох юм гэсэн нөхцөл байдал нь нэмэлт нотолгооны зүйл болон гарч байна. Энд хоёр дахь нөхцөл байдлыг тогтоохгүйгээр нэг дэх нөхцөл байдлыг тогтоох боломжгүй болж байна. Харин А худал мэдүүлэг өгсөн гэдэг нь тогтоогдвол Б-гийн мэдүүлэг нь А-г санаатай худал мэдүүлэг өгсөн хэргийн үндсэн нотлох баримт болно. Тэгэхээр хуулиар яг үүнийг нотлох ёстой гэж туйлын ойлгож болохгүй болохыг дээрх баримт харуулж байгаа юм.

## Нотолгооны хэмжээ, хязгаар

**Ач холбогдол.** Хэргийн нотолгооны хэмжээ, хязгаарыг тогтоосноор тухайн ажиллагаа илүү түргэн шуурхай бодитой явуулах боломжийг бүрдүүлэхэд ач тустай.

Нотолгооны зүйлийг хуульд тодорхойлж болдог бол хэмжээ, хязгаарыг шууд тогтоох боломжгүй. Тухайлбал, монголын нотолгооны түүхэнд гурван гэрчтэй бол асуудлыг шийдвэрлэж байсан нь нотолгооны хэмжээ, хязгаарыг хуульчлах гэсэн анхны оролдлого байжээ.

<p><b>Нотолгооны хязгаар</b> гэдэг нь гэмт хэргийн нотолгоо явагдах цар хүрээ</p>	<p>Тухайн хэргийн нотолгооны зүйлийг тогтооход хэдий хэмжээний газар нутаг, объект, хүмүүсийг хамруулах вэ гэдэг асуудлыг шийдвэрлэнэ.</p>
<p><b>Нотолгооны хэмжээ</b> гэдэг нь тухайн асуудлыг нотлохын тулд хэдий хэрийн баримт сэлт, мэдээлэл цуглуулбал зохистойг илэрхийлж байгаа үзүүлэлт</p>	<p>Асуудлыг баримтаар бодитойгоор тогтоохын тулд тодорхой хугацаанд хэдий хэрийн газар нутаг, объект, хүмүүсийн хүрээнд хичнээн нотлох баримт цуглуулбал илүү зохистой, хангалттай гэдгийг тогтоож байгаа явдал.</p>



Нотолгооны хэмжээ, хязгаарыг оновчтой тогтоох шаардлага эрх зүйн ямар хэрэг маргаан шийдвэрлэх явцад гардаг. Үүнд олон хүчин зүйлс нөлөөлдөг. Тухайлбал, гэмт хэргийн нотолгооны хэмжээ, хязгаарыг тогтооход нөлөөлж болох хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Гэмт хэрэг шийдвэрлэх ажиллагааны ямар шатанд гэмт хэргийн нотолгоо явагдаж байгаа эсэх;
- Эзэн холбогдогч нь тогтоогдсон эсэх;
- Олон үйлдэл, холбогдогчтой;
- Удааширсан буюу үргэлжилсэн үйлдэлтэй гэмт хэрэг эсэх;
- Их газар нутгийг хамарч үйлдэгдсэн эсэх;
- Нийлмэл гэмт хэрэг мөн эсэх;
- Нэг үйлдэлтэй боловч олон хохирогчтой эсэх;
- Хэргийн хугацаа их алдаж удсан эсэх;
- Цугларсан нотлох баримтуудын хооронд зөрчилдөөн байгаа эсэх;
- Тусгай техник, нарийн арга хэрэгсэлийг хэрэглэж үйлдэгдсэн эсэх;
- Тухайн хэрэгт холбогдсон этгээд гэм буруугаа хүлээсэн эсэх;
- Нууцлал алдагдсан эсэх;
- Мөрдөгч, прокурорын ур чадвар;
- Нотлох баримтууд устаж алга болсон тохиолдол байгаа эсэх;
- Олонд нэр хүнд нь түгсэн хүний эрх ашиг хөндөгдсөн эсэх;
- Бүлэг, зохион байгуулалттай, урдаас төлөвлөсөн, нууц, далд аргаар үйлдэгдсэн эсэх.

#### ДАСГАЛ АЖИЛ:

1. Сумын төвийн байранд зохион байгуулагдаж байсан сонгуулийн үйл ажиллагааны талаарх гомдлыг хянан шийдвэрлэх явцад 30 минутын хугацаанд болсон үйл явдлыг тогтоох шаардлага гарчээ. Энэ хугацаанд зуун хүн, олондоо хүндлэгдсэн улс төрч, таван цагдаа харжээ. Мөн нэг хүн 30 минутын дүрс бичлэг хийжээ.  
Нотолгооны хэмжээ, хязгаарыг хэрхэн тогтоох талаар ярилцана уу?
2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан хуулийг судлан маргаан тус бүрийн онцлогоос хамааран нотолгооны зүйл, хэмжээ, хязгаарыг тогтоон ярилцана уу?



## СЭДЭВ 5. НОТЛОХ АЖИЛЛАГАА

**Сэдвийн зорилго:** *Хэрэг маргааныг шийдвэрийн үндэслэл болох баримтуудыг цуглуулж, бэхжүүлэх ажиллагааг үр ашигтай явуулахад шаардлагатай хэлбэрийг хууль тогтоомжоос судлан үйл ажиллагаандаа тодорхой цэгцтэй хэрэглэх мэдлэг ур чадвар олгоход чиглэгдэнэ.*

**Хэргийг нотлох ажиллагаа** гэдэг нь хянан шийдвэрлэж буй хэрэгт хамааралтай болж өнгөрсөн үйл явдлыг нотлох баримтад тулгуурлан хуульд заасан үндэслэл, журмын дагуу сэргээн, бодит үнэнийг тогтоох танин мэдэхүйн үйл явц.

Нотлох ажиллагааны зорилго хэрэг маргаан шийдвэрлэх хууль тогтоомжоор тогтоогддог.

### Хэргийг нотлох ажиллагааны хэлбэр

**Хэргийг нотлох ажиллагааны хэлбэр** гэдэг нь хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд нотлох ажиллагааг хэрэгжүүлэх явдалтай холбогдуулан хуулиар тогтоосон буюу тогтоогдвол зохих журмыг тогтолцоо юм.

Нотлох ажиллагаа нь зөвхөн хуулийн хүрээнд явагдах ёстой бөгөөд ингэснээрээ зорилт хэрэгжих нэг нөхцөл болдог юм.

Нотлох ажиллагааны хэлбэрийн нэгдмэл байдал нь нотлох баримтын эрх зүйн гол шинжийг тогтоосон хуулийн хэм хэмжээгээр хангагддаг. Энэхүү хэлбэрт багтаж байгаа асуудлыг нэгбүрчлэн авч үзнэ. Үүнд:

1. Нотлох ажиллагааны хэлбэрийн үндэс болсон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, нотолгоонд тэдгээрийн гүйцэтгэх үүрэг;
2. Нотлох ажиллагааны баталгаа;
3. Нотолгоог хэрэгжүүлэх үед хэрэглэгдэх эрх зүйн албадлагын арга хэмжээ байна.

Нотлох ажиллагааг Монгол улсын нутаг дэвсгэр дээр хэн хэрэгжүүлж байгаагаас үл хамааран хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааныямар ч шатанд нотлох ажиллагааны хэлбэр нэгдмэл байдаг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт болон нотолгооны зорилго хэрэгжих эсэх нь нотлох ажиллагааны хэлбэрийг Монгол улсын хууль тогтоомжид хэрхэн тусгаснаас шууд шалтгаална.





## Хэргийг нотлох ажиллагааны зарчим

- Хууль ёсны зарчим,
- Иргэдийн эрх, эрх чөлөөг дээдлэн хамгаалах зарчим,
- Хүний халдашгүй байх эрхийг хамгаалах зарчим,
- Оролцогчдод эрх, үүргийг нь заавал тайлбарлан өгөх зарчим,
- Хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим,
- Шүүн таслах ажиллагааг гагцхүү шүүх хэрэгжүүлэх зарчим,
- Өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээр хангах зарчим,
- Гэм буруугүйн презумцийн зарчим,
- Хэргийн нотлох ажиллагаа Монгол хэл дээр явагдах зарчим,
- Нотлох ажиллагаа тасралтгүй түргэн шуурхай явагдах зарчим,
- Хэргийг нотлоход шинжлэх ухаан, технологийн ололтыг бүтээлчээр ашиглах зарчим,
- Мэтгэлцэх зарчим.

## Нотлох ажиллагааны баталгаа

**Хэргийг нотлох ажиллагаа** хэвийн явагдах бодит нөхцөл байдлыг бүрдүүлж буй цогц арга хэрэгсэл нь нотлох ажиллагааны баталгаа юм.

Нотлох ажиллагааны баталгаанд дараах үйл ажиллагаа хамаарна:

1. Нотлох баримтыг хамгаалах
2. Нотлох баримтыг хадгалах
3. Нотлох баримтыг тээвэрлэх
4. Оролцогчдод эрх, үүргийг нь тайлбарлан өгөх
5. Хэргийн нотлох ажиллагааны нууцлалыг хангах

### 1. Нотлох баримтыг хамгаалах

Нотлох баримтыг хамгаалах гэдэг нь хэрэгт ач холбогдол бүхий мэдээллийг агуулагч нотлох баримтын эх сурвалжийг гадны ямар нэг нөлөөллөөс хамгаалж нотолгооны ач холбогдлыг бууруулахгүй байхад чиглэгдсэн арга хэрэгсэл, нөхцөл байдлыг хэлнэ.

### 2. Нотлох баримтыг тээвэрлэх

Нотлох баримтыг тээвэрлэх гэдэг хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл агуулагч нотлох баримтын эх сурвалжийн бүрэн бүтэн байдал, нотолгооны ач холбогдлыг алдагдуулахгүйгээр нэг газраас нөгөө газар уруу зөөвөрлөх үйл явц юм.

### 3. Нотлох баримтыг хадгалах

Нотлох баримтыг хадгалах гэдэг нь хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл болон нотлох баримтын эх сурвалжийн бүрэн бүтэн байдал, нотолгооны ач

холбогдлыг алдагдуулахгүйн тулд тодорхой нөхцөл байдалд байлгах үйл явцыг хэлнэ.

#### 4. Оролцогчдод эрх, үүргийг нь тайлбарлан өгөх

Хууль сахиулагч, шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч бусад хүмүүст тэдгээрийн эрх, үүрэг болон үүргээ биелүүлээгүйн улмаас үүсэх үр дагаврыг тайлбарлан өгч, эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангаж байгаа ажиллагааг хэлнэ.

#### 5. Нотолгооны нууцлалыг хангах

Нотолгооны нууцлалыг хангах гэдэг нь шаардлагатай мэдээллүүдийг бусдад мэдэгдэхгүй байх талаар авч хэрэгжүүлж буй хэргийн нотлох үйл ажиллагааны явц, баталгааг хангах арга хэмжээ юм.

### Хэргийг нотлох ажиллагааны явцад хэрэглэх эрх зүйн албадлага

Хэргийн нотлох үйл ажиллагааны албадлага гэдэг нь нотолгооны эрх зүйн зайлшгүй нэг элемент бөгөөд нотлох үйл ажиллагаанд оролцогч этгээдүүдэд, хэрэгжүүлэгч хууль сахиулагчдаас хуульд заасан дүрэм, журмыг сахих, хууль ёсны шаардлагыг сайн дураараа биелүүлэхийг ямар нэг хэлбэрээр (эрх, эрх чөлөөнд нь хязгаарлалт тогтоон) шаардаж байгаа үйл явц юм.

Хууль зөрчсөн тохиолдол бүрийг илрүүлж, хариуцлага ноогдуулж байх гэдэг нь нотлох үйл ажиллагаа болон түүнтэй холбогдсон нийгмийн харилцааг зохицуулах явцад хуулиар тогтоосон журмыг зөрчсөн этгээдэд хуульд заасан шийтгэл хүлээлгэж байгаа төрийн албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явц юм.

Эрх зүйн албадлага		
Ял шийтгэл оногдуулах	Албан тушаалтнуудад сахилгын хариуцлага хүлээлгэх	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явцад шүүхээс хариуцлага хүлээлгэх

Нотлох ажиллагааны явцад хэрэглэх эрх зүйн албадлагыг дараах зорилгоор хэрэглэнэ:

1. Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх ажиллагаанд оролцож буй этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх ашгийг хамгаалах;
2. Нотлох ажиллагааг хуулийн дагуу явуулах боломжийг хангах;
3. Нотлох ажиллагааны дэг журмыг хангах;
4. Хэргийн биет нотлох баримт нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх ажиллагаа зохих журмын дагуу явуулах боломжийг хангуулах.



## Баримт цуглуулах ажиллагааны ойлголт

**Баримт цуглуулах ажиллагаа** гэдэг нь талууд эсхүл хуулиар эрх олгосон албан тушаалтнуудаас хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримт (мэдээлэл, нотлох баримтын эх сурвалж)-ыг хуулиар зөвшөөрсөн арга хэрэгслээр эрж хайх, олж илрүүлэн авч байгаа идэвхтэй үйл ажиллагаа юм.

Талууд эсхүл хууль сахиулагч хуулиар тогтоосон журмаар шүүхийн зөвшөөрөлтэй эсхүл шүүхийн зөвшөөрөлгүйгээр баримтыг цуглуулдаг. Баримт цуглуулахдаа иргэдийн амь нас, эрүүл мэндэд аюултай, эсхүл тэдний нэр төрийг гутаасан ажиллагаа явуулах, хүнлэг бус хэрцгий хандах нэр төрийг нь доромжлох хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, мэдүүлэг, дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэхийг хориглодог.

**1. Шүүхийн зөвшөөрөлтэй баримт цуглуулах.** Талууд эсхүл хууль сахиулагч тухайн ажиллагаа явуулах хуулиар тогтоосон үндэслэлээ баримтаа шүүхэд хүргүүлэн зөвшөөрөл авна. Тус зөвшөөрлийн дагуу тухайн ажиллагааг хэрэгжүүлэх хууль сахиулагчаар дамжуулан баримт цуглуулдаг.

Шүүхийн зөвшөөрөлтэй дор дурдсан аргаар баримт цуглуулж болно:

- Нэгжлэг хийх, нэгжлэг хийхээр орон байр, эзэмшил газарт нэвтрэн орох;
- Тээврийн хэрэгсэл, хүний биед нэгжлэг хийх;
- Шуудан цахилгаанаар явуулсан зүйлийг битүүмжлэх, хураан авах, түүнд үзлэг хийх;
- Компьютерийн мэдээлэлд нэвтрэх, компьютер хураан авах;
- Баримт бичиг, эд зүйл хураан авах. битүүмжлэх;
- Банкны сэжиг бүхий данс, дансны гүйлгээг зогсоох, эд хөрөнгийг хамгаалалтанд авах;
- Нууц мөрдөх ажиллагаа явуулах;
- Шарил шинжлэх;
- ДНХ-ийн шинжилгээ;
- Шүүх сэтгэгц гэм судлалын шинжилгээ;
- Хүний бие, эд эрхтэнд нэвтэрсэн аргаар үзлэг хийх, дээж авах;
- Насанд хүрээгүй болон эрхийн бүрэн чадамжгүй хүнд хийх шинжилгээ;

**2. Шүүхийн зөвшөөрөлгүйгээр баримт цуглуулах.** Талуудиргэнхуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхлыг хөндөхгүй, иргэдийн зан заншлын болон ёс суртахууны хэм хэмжээг гажуудуулалгүй, хүний амь нас эрүүл мэндэд аюулгүй аргаар шаардлага баримт, мэдээлэл олж цуглуулна. Үүнд иргэн, хуулийн этгээдээс тодруулга, мэдээлэл, судалгаа, тайлбар авах, үзлэг хийх, шаардлагатай туршилтыг өөрсдийн зардлаар явуулах зэрэг ажиллагаа орно. Түүнчлэн хувь хүн, хуулийн этгээдийн өөрийнх нь зөвшөөрснөөр хуульд заасан ажиллагааг явуулж мэдээлэл, баримт олж авч болно.

## Баримтыг бэхжүүлэх ажиллагааны ойлголт

**Баримтыг бэхжүүлэх ажиллагаа** гэдэг нь хуульд заасан албан тушаалтан дангаараа буюу бусдын тусламжтайгаар цуглуулсан нотлох баримтуудыг хуульд заасан журмаар дагуу бэхжүүлэх идэвхтэй ажиллагааг хэлнэ.

Баримтыг дараах аргаар бэхжүүлнэ.

1. Тэмдэглэл хөтлөх;
2. Бичлэг хийх (дуу, дүрс), гэрэл зураг авах;
3. Зурж, тэмдэглэх (тодорхой эд зүйл болон байгаль орчинг байгаа байдлаар нь буюу тоймлон харж зурах);
4. Схем, төлөвлөгөө үйлдэх (тухайн зүйлийг тодорхой дүрс тэмдэгтээр орлуулан зурж тэмдэглэх);
5. График, шугам зураг үйлдэх. (баримтыг техникийн маш нарийн үзүүлэлтээр нь зурж тэмдэглэх);
6. Эд зүйлийг бүхлээр бэхжүүлж авах (баримтыг байгаа байдлаар нь тухайлбал: унадаг дугуйг тэр хэвээр нь хураан авч бэхжүүлэх);
7. Тодорхой эд зүйлийн хэсэг буюу ул мөрийн буулгаж авах (тухайн эд ангийн тодорхой нэг хэсгийг нь авах, тухайлбал: ачааны машины дугуйг салган авах);
8. Хүний нүүрний гадаад төрхөөс загвар авч бэхжүүлэх (хүний нүүр, бусад эд эрхтэнг бүхлээр нь буюу тодорхой хэсгээр нь тусгай хэв загваравдаг бодисоор бэхжүүлж авах);
9. Нөхцөл байдлыг буюу бэхжүүлэн авсан зүйлийг сэргээн босгож бэхжүүлэх (дээр дурьдсан аргаар бэхжүүлж авсан хэв загварыг буцаан сэргээж бодит байдлаар нь тогтоох, хүний хэлсэн мэдүүлэг, бусад баримтын дагуу ямар нэг орчин, эд зүйлийг сэргээн босгон бэхжүүлэн авах);
10. Харьцуулан шинжлэхээр хэв загвар авах гэсэн нийтлэг аргууд байна.



## **Баримтыг бэхжүүлэхэд шинжлэх ухаан, технологийн ололтыг ашиглах нь**

Баримтыг бэхжүүлэхэд шинжлэх ухаан, технологийн ололтыг ашигласнаар дараах ач холбогдолтой. Үүнд:

1. Тухайн ажиллагаанд оролцож байгаа хүмүүсийн үйл хөдлөл, үг яриаг маш нарийн нэгбүрчлэн тусгах боломжтой.
2. Тухайн ажиллагааг шуурхай явуулах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлдэг.
3. Оролцогчдоос гаргах хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох.
4. Процессийн хүндрэл гарах явдлыг таслан зогсоох. Тухайлбал, мэдүүлэг өгөгч этгээд мэдүүлгээсээ буцах, нотолгоонд оролцогч этгээдүүд цуглуулсан баримтын ач холбогдлыг бууруулах төрөл бүрийн явдал гаргах зэргээс урьдчилан сэргийлэх.
5. Эрүүл мэндийн хувьд тэмдэглэлтэй танилцах, удаан хугацаагаар ярилцах боломжгүй тохиолдолд нотолгооны ач холбогдлыг алдагдуулахгүй байх гэх мэт болно.

Баримтыг техник хэрэгсэл ашиглан бэхжүүлж байгаа тохиолдолд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Техник хэрэгсэл ашиглаж байгаа талаар оролцогчдод мэдэгдэнэ.
2. Тухайн техник, хэрэгслийг ажиллуулахдаа шаардлагатай мэргэжилтнийг урьж оролцуулах.
3. Бичлэг хийхдээ хэсэгчилж хийхгүй аль болох бүтэн хийх.
4. Хэрэглэсэн техник хэрэгсэл, дүрс, дууг буулгасан хальс болон бусад зүйлсийн марк, загварыг тэмдэглэлд тодорхойлон бичсэн байх ёстой.
5. Ажиллагаа эхэлсэн, дууссан буюу завсарласан цаг, минутыг тусгана. Эдгээрийг хэлж бичүүлэх нь үр дүнтэй.

## **Баримтыг бэхжүүлэх журам, түүнийг зөрчсөнөөс үүсэх хууль зүйн үр дагавар**

Мөрдөгчид баримтыг бэхжүүлэхдээ дараах нийтлэг журмыг баримтална:

1. Баримтыг цуглуулах ажиллагааг нарийвчлан, дэс дараалан, нэг бүрчилэн бичнэ.
2. Тухайн ажиллагааг хэд дэх удаагаа явуулж байгааг тэмдэглэлд тусгана.
3. Баримтыг цуглуулж, бэхжүүлж байгаа хууль сахиулагч, оролцогч этгээдүүдийн нэр, шаардлагатай хаяг болон бусад мэдээллийг тусгаж, тэдгээрт эрх, үүргийг нь тайлбарлаж өгсөн эсэх
4. Баримтыг цуглуулахдаа дүрс, дууны бичлэг хийсэн, гэрэл зураг авсан, схем, гар зураг үйлдсэн эсэх.
5. Баримтыг цуглуулах талаар явуулж байгаа ажиллагаа эхэлсэн, дууссан огноо.

6. Тэмдэглэлд оруулсан завсар, өөрчлөлтийг тайлбарлана.
7. Баримтыг бэхжүүлж дууссаны дараагаар тэмдэглэлийг оролцогчдод уншиж өгсөн, уншуулсан эсэх талаар болон тэдний гаргасан санал хүсэлтийг тэмдэглэлд тусгаж гарын үсэг зуруулна. Тэмдэглэл хэд хэдэн хуудастай байвал түүний нүүр болгон дээр гарын үсэг зуруулна.
8. Тэмдэглэлийг тухайн ажиллагааны явцад буюу дууссаны дараа нь гаргацтай бичнэ.

### ДАСГАЛ АЖИЛ:

1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан хуулийг судлан тухайн процесс тус бүрийн нотлох ажиллагаа, баримт цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны онцлогийг гаргана уу.  
Хэрэг маргааныг хянан шийдвэрлэх хуулийн онцлогоос хамаарах нотлох ажиллагаа өөрчлөгдөж байгаа шалтгааныг ярилцана уу?



## СЭДЭВ 6. НОТЛОХ БАРИМТ, ТҮҮНИЙ ШИНЖ

**Сэдвийн зорилго:** *Нотлох баримтын ойлголт, үндсэн ба нэмэлт шинж, тэдгээрийн онцлогийг судалсанаарзохих шаардлагын түвшинд хэрэг маргаанд ашиглагдах баримтыг бүрдүүлэх, лэтгэлзээний үед тэдгээрийг шинжлэн судлах мэдлэг, дадал, хандлага олгоход чиглэгдэнэ.*


Ямар үйл явдал, түүнтэй холбоотой үүсэн гарах үйлдэл, эс үйлдэхүй нь өөрийн гэсэн ул мөрийг заавал үлдээдэг. Бусад үзэгдэл, үйл явцаас ялгагдах онцлог нь ул мөр үүсэх зүй тогтлоороо бий болохоос гадна түүнийг төрөл бүрийн байдлаар байгаагаас нь зориуд өөрчлөх, устгах, зохиомлоор бий болгох зэрэг гэмт этгээд болон гэмт хэрэгт хамтран оролцогч нарын идэвхтэй үйл ажиллагаа нөлөөлдөг.

Нотлох баримтыг хэнээс ч, хаанаас ч авч болох баримт мэдээлэл бус, гагцхүү хуульд заасан нотолгооны зүйл, хүрээ хязгаараас шалтгаалан танин мэдэх зүйлийн хэмжээ хязгаар, хүрээ тодордог.

### Нотлох баримтын төрөл

Нотлох баримтыг хэр нарийвчлан судалж байгаагаас хамааран хэд хэдэн төрөл болон ангилж болно. Тухайлбал:

- Мэдүүлгэн нотлох баримт
- Биет нотлох баримт
- Шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг
- Цахим нотлох баримт
- Бичиг баримт
- Бичмэл нотлох баримт
- Тодорхой ажиллагааны үр дүн гэх мэт.





Баримтад дээрх шаардлагын аль нэгийг хангахгүй бол нотлох баримт болох чадвараа алдана.

## 1. Хэрэгт хамааралтай байх:

Хэрэгт цугларсан нотлох баримтууд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэрт харилцан адилгүйгээр нөлөөлж байдаг. Зарим нь шийдвэрийн гол үндэслэл болж байхад бусад нь түүний ач холбогдлыг бууруулах эсхүл нэмэгдүүлж байдаг.

Тухайн баримтын нөлөөлөх чадвараас шалтгаалан хэрэгт хамааралтай байдал тодорхойлогдоно.

Тухайн баримт асуудлыг нотлоход хэрхэн нөлөөлж байгаагаас нь шалтгаалан:

**1 дүгээр зэргийн нотлох баримт:** асуудлыг шийдвэрлэхэд шууд нөлөөлөх нотлох баримт (үгүйсгэх буюу батлах)

**2 дугаар зэргийн нотлох баримт:** шийдвэрийг бататгах буюу эргэлзээ төрүүлэх нотлох баримт, түүнчлэн бусад нотлох баримтын нотолгооны ач холбогдлыг ихэсгэх буюу бууруулахад чиглэсэн байж болно.

**3 дугаар зэргийн нотлох баримт:** тухайн шийдвэрт огт нөлөөлөхгүй нотлох баримт гэж ангилна.

Нотолгооны ач холбогдол нь ихэвчлэн шийдвэр гаргах тухайн цаг үед тодорхойлогддог бөгөөд түүнийг тогтооход олон хүчин зүйлс нөлөөлнө. Үүнд:





1. Нотлох баримт нь анхдагч болон дамжмал байдлын алинаар нь илэрсэн;
2. Мэдүүлэг өгч байгаа этгээд урд худал мэдүүлэг өгч байсан эсэх;
3. Биет нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлсэн гэсэн баримт байгаа бол;
4. Мэдүүлэг өгч байгаа этгээдүүд хоорондоо танил тал болон хамаатан садны холбоотой түүнчлэн хэрэгт хувийн сонирхолтой байгаа бол;
5. Мэдүүлэг өгөгч этгээд зөрүүтэй олон мэдүүлэг өгсөн бол;
6. Тухайн нотлох баримт болсон үйл явдлаас илт буюу ямар нэг байдлаар зөрж байгаа бол;
7. Тухайн нотлох баримтыг үгүйсгэх адил тооны нотлох баримт байгаа бол нотлох баримтын нотолгооны зэрэглэл өөрчлөгддөг.

## **2. Хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдал нь мэдээлэл байдлаар илэрдэг**

Энэхүү мэдээлэл нь дараах байдлаар илэрнэ:

1. Мэдээлэл нь хүний ой ухаанд дурсамж байдлаар үлдэж энэ нь яриа, дохио зангаа гэх мэт хэлбэрээр илэрдэг.
2. Мэдээлэл нь биет эд зүйлд үлдсэн ул мөр байдлаар оршдог. Өөрөөр хэлбэл, биет эд зүйлд мэдээлэл нь эвдэрсэн, зурагдсан, хэлбэр, дүрсний өөрчлөлт байдлаар оршино.
3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүн нь хэрэгт ач холбогдол бүхий мэдээллийг агуулдаг. Тухайлбал, мөрдөн байцаалтын туршилт, таньж олуулах ажиллагааны үр дүн гэх мэт.
4. Мэдээллийг эх сурвалжаас нь шинжлэх ухаан, техник, урлаг, гар урлалын тусгай мэдлэгийг ашиглан шинжилгээ хийлгэх замаар олж авдаг. Шинжээчийн дүгнэлт, мэдүүлэгт мэдээлэл агуулагдаж байдаг.
5. Хэргийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл нь гэрэл болон кино зураг, дүрс, дууны бичлэгт агуулагдаж болно.
6. Шүүх хуралдааны тэмдэглэл нь өөрөө шүүхийн шийдвэрийн үндэслэл болох нотлох баримт боловч тэмдэглэл нь өөрөө гэмт хэргийн мэдээлэл агуулсан байх тохиолдол бий.
7. Хүний бичсэн, баталсан баримт бичиг хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл агуулагддаг.
8. Мэдээдэл нь өвөрмөц байдлаар илэрч болно. Шинжлэх ухаан технологийн асар хурдацтай хөгжил нь мэдээллийн шинэ, шинэ хэлбэрийг бий болгож байдаг. Тухайлбал, компьютер, болон түүний сүлжээгээр дамжиж байгаа болон хадгалагдаж байгаа мэдээлэл нь ихээхэн өвөрмөц байдлаар илэрдэг.

### 3. Мэдээлэл эх сурвалжтай байна

Баримтын эх сурвалж нь хэрэгт ач холбогдол бүхий мэдээллийг агуулж байдаг учир хэргийн нотолгоо нь юуны түрүүнд ач холбогдолтой мэдээлэл олж авахад чиглэгдэхээсээ илүүтэйгээр баримтын эх сурвалжийг олж тогтооход чиглэгдэнэ. Мэдээлэл эх сурвалж хоёр нь байнга хосолж байх бөгөөд мэдээлэлгүй эх сурвалж гэж байхгүй, эх сурвалжгүй мэдээлэл гэж гэж байдаггүй.

Хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл агуулагч хүн, амьтан, эд зүйл, бичиг баримт, хүрээлэн буй орчин болон бусад зүйлсийг **баримтын эх сурвалж** гэнэ.

Баримтын эх сурвалж нь хүн, эд зүйл, бичиг баримт, хүрээлэн буй орчин, амьтан, ургамал, компьютерийн мэдээлэл, сүлжээ зэрэг биет байдлаар илэрнэ.

### 4. Хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл бүхий баримтын эх сурвалжийг олж авсан анхдагч эх сурвалж нь тодорхой байна.

“Гэрч, хохирогч мэдүүлгийнхээ эх сурвалжийг зааж чадаагүй бол тэр нь нотлох баримт болохгүй.” “Нэр хаяггүй мэдээлэл дангаараа нотлох баримт болохгүй “

Анхдагч нотлох баримтын эх сурвалжаас мэдээлэл авч байгаа тохиолдолд анхдагч эх сурвалжаа заах шаардлагагүй.

Хэргийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг дам байдлаар шууд бусаар олж авсан бол тухайн хүн хэнээс, хаанаас, ямар байдлаар олж авснаа хэлж байгаа нь мэдээллийн эх сурвалжийг зааж өгч байгаа явдал.

Гэрч мэдүүлгийнхээ эх сурвалжийг зааж өгсөн боловч тэр нь нотлогдохгүй бол тэдгээрийг нотлох баримтаар тооцохгүй байж болно. Мөн хаанаас, хэнээс, хэрхэн олж авсан нь мэдэгдэхгүй, хангалттай баталж чадахгүй бол тэршийдвэрт шууд нөлөөлөх нотлох баримт болохгүй.

Хуульд заасан үндэслэл журмын дагуу явуулсан гүйцэтгэх ажлын үр дүн буюу мэдээллийг ил гаргаж болох ба түүний эх сурвалжийг нууцалдаг. Энэ тохиолдолд нотолгооны эх сурвалж нь гүйцэтгэх ажил байна.

### 5. Мэдээллийг нотлох баримтын эх сурвалжаас хуульд заасан үндэслэл журмын дагуу олж авсан байна.

Өмгөөлөх, яллах эсхүл мэтгэлцэгч талууд шүүхэд баримтаа хуульд заасан үндэслэл журмын дагуу цуглуулдаг.

Хууль зөрчиж мэдээллийг эх сурвалжаас олж авсан бол нотлох баримтын ач холбогдлоо алдана.



Мэдээлэл олж авсан арга нь ил тодорхой байх ёстой. Хэрэв ямар аргаар тухайн мэдээллийг эх сурвалжаас олж авсан нь мэдэгдэхгүй бол нотлох чадвараа алдах эрсдэлтэй.

“Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалвал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсын батлан хамгаалах үндэсний аюулгүй байдал нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.” гэсэн заалтын дагуу иргэд баримт сэлт мэдээлэл чөлөөтэй эрж хайдаг.

### ДАСГАЛ АЖИЛ:

1. Б, Т нар ОХУ-н Ангарск хотод байхдаа Т нь Б-г зодож баруун нүдийг нь сохолж хүнд гэмтэл учруулжээ. Б нь Монгол Улсад ирж цагдаагийн байгууллагад гомдол гаргасан ба цагдаагийн байгууллага Т-д эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна. Энэ хэрэгт ОХУ-д эмнэлэгт эмчлүүлсэн тухай бичиг баримт нотлох баримтын эх сурвалж болж чадах уу?
2. Хууль сахиулагч Г. хэргийн газрын үзлэгийг явуулахдаа “М-300 soni” маркийн дүрс бичлэгийн аппаратыг ашиглан явуулжээ. Шүүх хуралдаан дээр дүрс бичлэгийг үзүүлэхэд тухайн бичлэг чанарын шаардлага хангасангүй. / Дүрс нь гарахгүй дуу нь гарч байв./  
Энэ нь уг хэрэгт нотлох баримт болж чадах уу?
3. Өмгөөлөгч шүүхийн зөвшөөрөлтэйгээр бусдын орон байрнаас эд мөрийн баримт хурааж авалгүйгээр байрны оршин суугчаас зөвшөөрөл авч хэрэгт ач холбогдолтой баримтыг авах ажиллагааг өөрийн гар утсаараа бичиж бэхжүүлж авчээ.  
Өмгөөлөгчийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгнө үү?
4. Нэгэн эмэгтэй шөнө унтаж байгаад өөрийнх хүүг нэгэн хүн алж байгаагаар зүүдэлж сэрээд тэр даруй цагдаад хэлжээ. Маргааш өглөө хүү нь ээжийнх нь зүүдэнд харагдсан байдлаар амиа алдсан байв. Эх өгсөн мэдүүлэгтээ зүүдэнд харагдсан бүх зүйлээ тэр битгий хэл гэмт хэрэгтний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгчээ. Шалгаж үзэхэд сэжигтэн тэр үед хаана байснаа нарийн хэлж чадахгүй байсан ба гэмт хэрэг үйлдсэн байж болох зэвсэг түүний гэрийн ойролцоогоос олджээ.  
Мэдүүлэг нотлох баримт болох уу?

## СЭДЭВ 7. НОТЛОХ БАРИМТЫН ЦОГЦ БАЙДАЛ

**Сэдвийн зорилго:** *Нотлох ажиллагааны явцад цугларсан шүүхээр хэлэлцэгдэх нотлох баримтууд нь дангаар бус хэд хэдэн баримтууд нэг нэгнээ нөхсөн, уялдсан, холбогдсон байдлаар цогц тогтолцоо бүрдүүлдэг талаар тэдлэг олж авсанаараа шүүхийн хэлэлцүүлгийн үед мэтгэлзэхдээ тэдгээрийг ашиглах чадвар, хандлага төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.*

Хэргийг шалгах явцад бие биеэ үгүйсгэсэн, бататгасан өөр өөр онцлог шинжтэй нотлох баримтууд цугларч бэхжүүлэгддэг ба эдгээрт үндэслэн ямарваа нэг үйл явдал, баримтыг тогтоодог. Дан нотлох баримтаар ямар ч асуудлыг шийдвэрлэх боломж хязгаарлагдмал.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр гаргахад эсхүл бодит үйл баримтыг тогтооход чиглэгдэн цугларсан, хоорондоо шууд ба шууд бусаар харилцан холбоотой нотлох баримтуудын цогцолбор буюу тогтолцоог хэргийн **нотлох баримтын цогц байдал** гэнэ.

Энэхүү цогц байдал нь шийдвэр гаргахад нөлөөлөх үндэслэл болж байгаагаасаа хамааран харилцан адилгүй байна. Нэг цогцоор байгаа нотлох баримтууд нь ямар ч хамаагүй эрээвэр хураавар мэдүүлэг, баримтуудын цуглуулга бус, тодорхой нэг асуудлыг шийдэхэд чиглэгдсэн эмх цэгцтэй, бие биентэйгээ харилцаа холбоотой, нэгдмэл, цогц байдлаар оршдог. Энэ нь нотолгооны зорилго болох бодит үнэнд хүрэх явц нь нотлох баримт хэр цогц байдлаар цугларснаас ихээхэн шалтгаална.

Хэргийн нотлох баримтын цогц байдал нь:

1. Нотлох баримтын цогц байдлын гишүүн,
2. Нотлох баримтын цогц байдлын холбоос,
3. Нотлох баримтын цогц байдлын чиг үүрэг,
4. Нотлох баримтын цогц байдлын олонлог байдал зэрэг хэсгээс бүрдэнэ.

**Нотлох баримтын цогц байдлын гишүүн** нотлох баримт бүр тодорхой нөхцөл байдлыг нотолдог. Нэг цогц байдлаар оршин буй нотлох баримтууд нэг систем үүсгэдэг. Гишүүн нотлох баримтууд нь үндсэн нотлох баримтуудаа бататгасан, эсхүл бие биентэйгээ нөхцөлдсөн байдлаар оршдог.

**Нотлох баримтын цогц байдлын холбоос** гэдэг нь гишүүдийн гишүүн нотлох баримт (цогц нотлох баримтын) хоорондын уялдаа, харилцан хамаарлыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, цугларсан цогц нотлох баримтын гишүүн нотлох



баримтууд нь хэрхэн яаж тухайн үйл баримттай холбогдон тодорхойлж байгааг гаргаж ирдэг.

**Нотлох баримтын цогц байдлын чиг үүрэг** гэдэг нь тогтоох гэж байгаа нөхцөл байдлыг тогтоож байгаа цогц нотлох баримтууд нь шийдвэр гаргахад ямар үүрэгтэй байгааг илэрхийлсэн ойлголт юм. Үндсэн ба нэмэлт нотлох баримтууд нь өөр өөрийн гэсэн чиг үүрэгтэй байхаас гадна гол болон туслах үйл баримтыг тогтоож байгаа нотлох баримтууд нь мөн адил тодорхой чиг үүрэгтэй. Эдгээр нотлох баримтууд нь харилцан бие биеэ нөхцөлдүүлэн нотолгооны зорилгыг хангадаг.

**Нотлох баримтын цогц байдлын олонлог байдал** гэдэг нь тухайн шийдвэр гаргахын тулд олон талаас нь бүрэн дүүрэн судалж тогтоож байх шаардлагыг илэрхийлдэг. Тиймээс тодорхой жижиг хэсэг үйл баримтыг тогтоосон нотлох баримтууд нь нийлж байж нэгдсэн дүгнэлтэд хүрнэ.

**Нотлох баримтын цогц байдлын бүрэн дүүрэн байх шинж** гэдэг нь тогтоох гэж буй үйл явдал, нөхцөл байдлыг болон талаас нь шаардлагатай бүх ажиллагаа явуулан шийдвэр гаргахад хүрэлцэхүйц нотлох баримт цугларсан байхыг ойлгодог. Өөрөөр хэлбэл нотлох баримтад тусгагдсан мэдээлэл, эх сурвалж болгоныг мухарлан шалгаж, тогтоосон үйл баримтыг үгүйсгэж болох бүх таамаглалуудыг эцэслэн шалгасан байна гэсэн үг юм.

**Нотлох баримтын цогц байдлын үнэн бодитой байх шинж** гэдэг нь нотолгооны зүйлийг тогтоохдоо хангалттай нотлох баримт цуглуулахын зэрэгцээгээр тэдгээр нь бодитой байх ёстой. Өөрөөр хэлбэл, тогтоосон зүйл нь үнэнд ойртож очих магадлал нь өндөр байна гэсэн үг. Тухайлбал, гэрчийн хүний зөвхөн нүүрийг нь харсан, хоёрдахь нь хувцсыг сайн харсан, гуравдахь нь үйл хөдлөлийг нь сайн харсан гэх мэтээр хүн болгон хувь хүний онцлог байдлаас шалтгаалан тодорхой үйл явдлыг харилцан адилгүй тусгаж авдаг. Эд зүйл ч гэсэн бүтцийн онцлогоос шалтгаалан өөр, өөр ул мөрийг үлдээдэг. Тиймээс нотлох баримтуудын дутагдалтай талыг бусад нотлох баримтуудын дэвшилттэй талаар нөхөж асуудлыг илүү бодитойгоор тогтоох болно.

Баримтын эх сурвалжаас шаардлагатай бүх мэдээллийг олж авсан, одоо цаашид мэдээлэл гарах боломжгүй эсхүл баримтын эх сурвалжаас шаардлагатай мэдээлэл бүрэн гүйцэд олж аваагүй байна гэсэн хандлагыг **нотлох баримтын цогц байдлын итгэлтэй байх шинж** гэнэ.

**Нотлох баримтын цогц байдлын нэг гол шинж нь хүлээн зөвшөөрөхүйц байх шинж** юм. Тогтоогдсон үйл баримтыг үгүйсгэх ямар нэг нотлох баримт болон цогц нотлох баримтаар тогтоогдсон үйл явдлыг үгүйсгэх ямар нэг нотлох баримт буюу нөхцөл байдал байхгүй байгаа тохиолдлыг **цогц нотлох баримтын хүлээн зөвшөөрөхүйц байх шинж** гэнэ.

Зөвшөөрөхүйц байх шинжийг тодорхойлоход цогц нотлох баримтууд ихээхэн үүрэгтэй байхаас гадна тэдгээрийг зангидан үндэслэлтэйгээр тайлбарлаж байгаа хүмүүсийн үнэлэлт, дүгнэлт голлох үүрэг гүйцэтгэнэ.

Хангалттай үндэслэл бүхий, үнэмшилтэй дүгнэлт, тайлбар өгөх явцад нотлох баримтад хэд хэдэн мэдээлэл агуулсан байх тохиолдол бий. Иймээс шаардлагатай гэсэн мэдээллийг нотлох баримтын эх сурвалжаас буюу нотлох баримтаас авч нэгтгэн цогц дүгнэлт гаргаж байгааг **нотлох баримтын нэгдмэл байх шинж** гэнэ.

Нотлох баримтын цогц байдал түүнчлэн түүний дотоод мөн чанар, хоорондын уялдаа холбоо зэрэг бусад байдлыг тодорхойлоход танин мэдэхүйн төрөл бүрийн аргуудыг зөв хослуулан хэрэглэх нь түүний нотолгооны ач холбогдлыг ихэсгэх буюу бууруулахад ихээхэн чухал үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, мэтгэлцэгч талууд цугларсан нотлох баримтууд дээр үндэслэн оюун ухаан, сэтгэхүйн хүчин чадлаараа тухайн нотлох баримтуудыг амилуулан шийдвэр гаргахад нөлөөлөх боломжтой болгодог.

## ДАСГАЛ АЖИЛ:

Аж үйлдвэрийн барааны дэлгүүрт гарсан хулгайн хэрэг дээр дараах баримтууд тогтоогджээ. Эмэгтэй С дэлгүүрээс алдагдсантай төстэй хоёр ноосон цамц зах дээр зарж яваад баригдсан бөгөөд танил Л уг цамцнуудыг заруулахаар өгсөн, комиссын дэлгүүрийн хавьд согтуу хүнээс хямдхан авсан гэж ярьж байсан гэж тэрээр мэдүүлжээ. Л-ийг байцаахад комиссын дэлгүүрийн тэнд үл таних хүнээс хямд авсан хоёр ноосон цамцыг заруулахаар С-д өгсөн нь үнэн гэв. Хулгай хийгээгүй, тэр шөнө гэртээ байсан, гэрээс ерөөсөө гараагүй гэж Л мэдүүлж байв. Гэрчээр байцаагдсан Л-ийн эхнэр нь хулгай гардаг хагас сайнаас бүтэн зайнд шилжих шөнө Л. гэртээ байсан, хаашаа ч яваагүй, харин түүнийг хүнээс цамц худалдаж авсан талаар мэдэх зүйлгүй хэмээн мэдүүлэв. Баригдах үедээ Л. алтан хүрээтэй оосоргүй цаг хаях гэж завдаад амжаагүй нь мэдэгдэв. Цагний механизмийн номер нь дэлгүүрээс алдагдсан цагны паспорт дээр байгаа номертой тохирч байв. Яагаад цагийг хаях гэсэн, ямар учиртай цаг болохыг Л тайлбарлаж ярихаас татгалзсан бөгөөд маргааш нь болохоор баригдах тэр мөчид хэн нэг хүн уг цагийг миний хувцасны халаас руу шургуулсан байсан учир намайг эхнээсээ л зохион байгуулалттай гүтгээд байна гэж үзсэн учир сандрахдаа би хаясан гэж тодотгож мэдүүлжээ.

*Асуулт: Нөхцөл байдлыг үнэлэн ярилцана уу?*

*Хяналтын асуулт:*

1. Нотлох баримтын цогц байдал гэж юу вэ? Түүнийг тодорхойлохын ач холбогдлыг харилцан ярилцана уу?
2. Нотлох баримтын цогц байдлын холбоосыг илэрхийлсэн жишээ гарган ярилцана уу?
3. Нотлох баримтын цогц байдлын гишүүнийг илэрхийлсэн жишээ гарган ярилцана уу?
4. Нотлох баримтын цогц байдлын чиг үүргийг илэрхийлсэн жишээ гарган ярилцана уу?
5. Нотлох баримтын цогц байдлын олонлог байдлыг илэрхийлсэн жишээ гарган ярилцана уу?
6. Нотлох баримтын цогц байдлын үндсэн шинжийг илэрхийлсэн жишээ гарган ярилцана уу?



## СЭДЭВ 8. НОТЛОХ БАРИМТЫГ ҮНЭЛЭХ, АШИГЛАХ

**Сэдвийн зорилго:** *Тодорхой нотлох баримт, түүний бүрдэх, өөрчлөгдөх, цуглуулж, бэхжүүлж авах зэрэг олон онцлогийг харгалзан тэдгээрийг шүүхээр хэлэлцүүлэх эсэх, шийдвэрийн үндэслэл болгох эсэх гаргалгааг хууль зүйн төдийгүй онолын үндэслэлтэй гарган мэтгэлцэхэд шаардлагатай тэдлэг, хандлага төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.*

**Нотлох баримтыг үнэлэх** нь шүүх, талууд эзэмшсэн мэргэжил, ажлын дадал, ур чадварын үндсэн дээр танин мэдэхүйн төрөл бүрийн аргын тусламжтайгаар нотлох ажиллагааны бүхий л явцад ашиглагддаг сэтгэхүйн ажиллагаа юм.

Нотлох баримтыг цуглуулах явцад илэрч байгаа нотлох баримтыг хэрхэн ямар аргаар цуглуулах, түүнээс үндэслээд дараагийн нотлох баримтыг яаж олж болох талаар зөв шийдвэр гаргаж улмаар нотолгооны зорилгыг хангахад нотлох баримтыг үнэлэх явц нь чухал үүрэгтэй.

Нотлох баримтыг бэхжүүлэх явцад нотлох баримтыг ямар аргаар хэрхэн бэхжүүлэх түүнийг тэмдэглэлд хэрхэн тусгах шийдвэр гаргахад нь үнэлэх ажиллагаа зайлшгүй.

Нотлох баримтыг шалгах нь нотлох баримтыг үнэлэх үйл явцаас шууд хамраалтай бөгөөд мөрдөгч, шүүх, прокурор нь нотлох баримтуудыг өөрийн дотоод итгэлээр үнэлж нэмэлт нотлох ажиллагаа явуулж шалгах эсэхийг шийддэг.

Нотлох баримтыг хэрэглэх үе шатанд нотлох баримтыг үнэлэх өөрөөр хэлбэл тухайн нотлох баримтууд шийдвэр гаргахад хангалттай, бүрэн дүүрэн эсэхэд үнэлэлт өгсний үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тодорхой шийдвэр гаргахад үндэслэл болгоно.

Нотлох баримтыг үнэлэхдээ урьдаас хөтөлбөргүй үнэн гэж тогтоосон ямар ч нотлох баримт байж болохгүй. Учир нь гэмт этгээдүүд өөрийн хууль бус үйлдлийг нуун дарагдуулах, хариуцлага хүлээхгүйн тулд хууль хяналтынхан болон бодит үнэнийг тогтоох хүсэл сонирхолтой хүмүүсийг төөрөгдүүлэхийн тулд нөхцөл байдлыг зохиомлоор өөрчлөх, нотлох баримтуудыг хуурамчаар бүрдүүлдэг.



## Нотлох баримтыг үнэлэхэд баримтлах үндсэн мөрдлөгүүд:

1. Нотлох баримтыг талууд эсхүл өмгөөлөгч, прокурорын мэтгэлцээний үр дүнд бий болсон нотлох баримтыг тулгуурлан шүүх өөрийн дотоод итгэлээрээ үнэлж шийдвэр гаргана.
2. Нотлох баримтыг шүүгч түүнчлэн хуульд заасан тохиолдолд иргэдийн төлөөлөгч өөрийн дотоод итгэлээр үнэлнэ. Урьдаас хөтөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч баримт байж болохгүй. Хэдий хууль сахиулагчид тухайн хүний гэм буруутай гэдгийг мэдсэн, нотлох баримт хэн нэгний талд байгаа нь илт тогтоогдож байгаа ч гэсэн шүүхийн шийдвэр гартал хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн буруутай гэж тооцох ёсгүй.
3. Нотлох баримтыг шүүгч дотоод итгэлээр үнэлэхдээ өөрт төлөвшсөн эрх зүйн ухамсарыг удирдлага болгоно. Эрх зүйн ухамсар гэдэг нь нийт эрх зүйн зорилтын мөн чанарыг зөв тодорхойлсон эрх зүйн үзэл санааны нийлбэр юм. Хуулийн агуулгыг зөв ойлгон тайлбарлах, хэрэглэх, хэргийн бодит үнэнийг тогтоож, болж өнгөрсөн үйл явцад эрх зүйн зөв дүгнэлт өгөх явдал нь чухал.
4. Нотлох баримт нь тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, хангалттай, үнэн зөв, эргэлзээгүй хуульд журам, арга хэрэгслээр цугларсан эсэх талаас нь үнэлэлт өгнө.
5. Нотлох баримтыг үнэлэхдээ хуулийн заалтыг хатуу баримтлах үүрэгтэй. Хуулийг ягштал баримтлах нь хэргийн бодит үнэнийг хуулийн дагуу тогтоох зайлшгүй чухал нөхцөл болдог.

## Нотлох баримтыг ашиглах

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль сахиулагч, шүүхээс гаргаж буй шийдвэр нь баримтад тулгуурлана. Хэн ч өөрийн үзэл бодол, хувийн сонирхлын үүднээс хандахгүй. Нотлох ажиллагааны явцад бий болсон баримтыг шүүх хэлэлцүүлж, нотлох баримтын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тэдгээрийг шийдвэртээ тусгах ёстой.

**Нотлох баримтыг ашиглах** гэдэг нь хуульд заасан үндэслэл журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтад тулгуурлан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэрийн үндэслэлд тусгахад чиглэгдсэн үйл явц юм.





### **Шүүх дараах нотлох баримтыг шүүхээр хэлэлцэхгүй байж болно:**

- Нийгэмд хэвшмэл ойлголтыг нотлох баримт;
- Хэрэгт хамааралгүй баримтыг тодруулах гэсэн нотлох баримт;
- Тухайн шийдвэрт хамааралгүй нөхцөл байдлыг нотлох баримт;
- Урд нь шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримт;
- Бүхэлдээ зохисгүй эсхүл олж авах боломжгүй нотлох баримт;
- Ажиллагааг санаатайгаар сунжруулах зорилгоор гаргаж ирсэн нотлох баримт.

Хууль зөрчиж олж авсан баримт нотлох чадвараа алдах бөгөөд шүүх тэдгээрт тулгуурлан шийдвэр гаргахыг хориглоно.

### **Шүүх дараах баримтыг нотлох баримтаас хасч болно:**

- Хуульд шүүгчийн зөвшөөрлөөр хийгдэх тухай заасан мөрдөх ажиллагааг шүүгчийн зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэсний дүнд олж авсан баримт;
- Хойшлуулшгүй тохиолдолд шүүгчийн зөвшөөрөлгүй хийгдсэн мөрдөх ажиллагаагаар олж авсан баримтыг хүлээн зөвшөөрүүлэх мөрдөх ажиллагааны зөвшөөрлийн шүүгч нөхөж олгоогүй бол;
- Эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар эсхүл хүний нэр төрийг доромжлон харьцсаны дүнд олж авсан ямарваа баримт, мэдүүлэг;
- Гэрчээр оролцож болохгүй хүнээс авсан мэдүүлэг;
- Хууль зөрчиж олж авсан бусад баримт, мэдүүлэг.

### **Шүүх дараах тохиолдолд нотлох баримтын тодорхой хэсгийг үнэлэхээс татгалзаж, нотлох баримтаас хасч болно:**

- Тухайн нотлох баримтыг олж авсан нөхцөл байдал нь нотлох баримтын үнэн зөв байдалд эргэлзэх бодит эргэлзээг төрүүлж байвал;
- Зөрчлийн шинж чанар болон тухайн баримтыг олж авсан нөхцөл байдал зэрэг бүх нөхцөл байдлыг харьцуулан үзэхэд, нотлох баримтын ач холбогдол нь хүний эрх болон хянан шийдвэрлэх ажиллагааны шударга, эрх тэгш байдлаас давсан байвал.

## **Хууль бус нотлох баримтаас бий болсон нотлох баримт**

Хууль бус үйл ажиллагааны явцад бий болсон баримтад тулгуурлан олж авсан нотлох баримт, шүүхэд хэлэлцэгдэж байгаа нотлох баримт хооронд шалтгаант холбоо байгаа, эсхүл шүүхэд хэлэлцэгдэж байгаа нотлох баримтыг эхний зөрчил гаргасан хууль сахиулах байгууллагын ажилтан, прокурор, өмгөөлөгчийн идэвхтэй үргэлжилсэн үйл ажиллагааны дүнд олж авсан тохиолдолд хууль бус гэж үздэг. (Хортой модны жимсний онол)

## **Гүйцэтгэх ажлын арга хэрэгсэл ашиглаж авсан баримт материалыг нотлох баримтын хэмжээнд үнэлэх нь**

Гэмт хэргийн талаар хуульд заасан үндэслэл, нөхцөл, журмын дагуу гүйцэтгэх ажлын арга хэрэгсэл ашиглаж авсан баримт, материалыг шүүх нотлох баримтын хэмжээнд үнэлж болно. Нотлох баримт хэмжээнд үнэлэхдээ баримт материал цуглуулах, илрүүлж бэхжүүлэх үйл ажиллагааны эх сурвалжийг нууцалж шүүхийн хуралдаанд тухайн баримт материалыг шинжлэхдээ шүүхийн хэлэлцүүлгийг хэсэгчилсэн байдлаар хаалттай явуулдаг.

Гүйцэтгэх ажлын шугамаар авсан баримтыг хуулийн дагуу авагдсан эсэхийг тодруулах, тус ажиллагаатай холбоотой байдлыг тодруулахаар тухайн ажиллагааг удирдаж байсан хүнийг шүүхэд гэрчээр дуудаж болдог.

### **ДАСГАЛ АЖИЛ:**

1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны /эрүү (гэмт хэрэг), иргэн, захиргаа, Үндсэн хуулийн цэц/ явцад нотлох баримтад тулгуурлан ямар ямар шийдвэр гаргадаг, нотлох баримтыг үнэлэх онцлог, нотлох баримтыг хэлэлцэхээс татгалзах, хасах үндэслэл журмын талаар ярилцана уу?
2. Хэнтий аймгийн төвд оршин суух Зууннастын гэрийн тэжээвэр нохой иргэн Гантигийг хазаж хүнд гэмтэл учруулжээ. Энэ нь хохирогчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлтээр нотлогджээ. Харин өөр нотлох баримтгүй байв. Зууннаст манай нохой сул байдаг, хүн хазгах гээд байдаг нь үнэн, гэвч би нохойгоо хүн хазаж байгааг хараагүй гэжээ. Гэтэл прокуророос нохой Гантигийг хазсан байж болно, гэхдээ Зууннастын нохой хазаж гэмтэл учруулсан гэдэг нь тогтоогдохгүй байна. Иймд Зууннастын нохой хэдэн шүдтэй байсныг тогтоож, Гантигийн шархтай харьцуулж үзэх, хэрэв нохойны шүд унасан бол хэзээ унасныг тогтоо гэсэн шийдвэр өгчээ. Прокурорын шийдвэрт үнэлэлт дүгнэлт өг.



## СЭДЭВ 9. МЭДҮҮЛГЭН НОТЛОХ БАРИМТ

**Сэдвийн зорилго:** *Мэдүүлгэн нотлох баримт, түүний бүрдэх, өөрчлөгдөх, цуглуулж, бэхжүүлж авах зэрэг олон онцлогийг харгалзан тэдгээрийг шүүхээр хэлэлцүүлэх эсэх, шийдвэрийн үндэслэл болгох эсэх гаргалгааг хууль зүйн төдийгүй онолын үндэслэлтэй гарган тэтгэлцэхэд шаардлагатай тэдлэг, хандлага төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.*

Нотлох баримт болгон өөр өөрийн гэсэн сул болон давуу талтай байдаг. Мэдүүлгэн нотлох баримтын давуу тал:

- гэмт хэргийн нөхцөл байдлын талаар илүү тодорхой, дэлгэрэнгүй, бүрэн дүүрэн мэдээлэл олж авах боломжтой,
- мэдүүлэг өгөх хүнийг олж авах, түүнийг байцаах нь бусад төрлийн нотлох баримтыг олж авах, түүнээс ул мөрийг хайж бэхжүүлэхээс харьцангуй хялбар,
- мэдүүлгэн нотлох баримтыг олж авах, шинжлэх хэлбэр нь хүний ердийн гэж хэлж болох харилцаанд тулгуурлагдах тул ойлгож, таньж мэдэхэд харьцангуй дөхөмтэй.

**Сул тал:** мэдүүлгэн нотлох баримт мэдүүлэг өгч буй хүний сэтгэцийн байдал, болсон явдалд хандах түүний хандлага, биеийн байдал, мэдрэхүйн эрхтний согог, ой тогтоолт, тухайн үеийн анхаарал төвлөрсөн байдал зэрэг биологи, сэтгэл зүйн олон хүчин зүйлстэй холбоотой байдаг тул мэдүүлэг авахдаа болон үнэлэхдээ тэд бүгдийг тооцох ба үнэний магдлалын зэргийг тогтооход ихээхэн бэрхшээлтэй тулгардаг. Өөрөөр хэлбэл, мэдүүлэг өгч буй этгээд болсон явдлыг яаж мэдэрч тусгаж авсан, түүнийг хэрхэн ойлгосон зэргийг сайтар танин мэдсэний үндсэн дээр нотлох баримтын хэмжээнд үнэлэх боломж бүрдэнэ. Зарим үед мэдүүлэг өгсөн этгээд болсон байдлыг зөв тусган авах, ойлгох, илэрхийлэх чадвартай эсэхийг тусгай мэдлэгийн тусламжтайгаар шалгуулан тогтоолгохоор шинжээч томилох шаардлага гардаг.

### Мэдүүлгэн нотлох баримтын үндсэн шинж

Бусад төрлийн нотлох баримтын нэгэн адил мэдүүлгэн нотлох баримтад нийтлэг шаардлага тавигдахаас гадна, зөвхөн энэ төрлийн нотлох баримтад хамаарах тусгай шаардлагуудтай.

#### 1. Үндсэн шинж:

- агуулгын хувьд тухайн гэмт хэрэг хамааралтай байх,
- хэрэгт хамааралтай нөхцөл байдал нь мэдээлэл хэлбэрээр илэрнэ,
- мэдээлэл нь эх сурвалжтай байна,
- эх сурвалжтодорхой байх,
- мэдээллийг эх сурвалжаас хуулийн дагуу олж авсан байх.

## 2. Нэмэлт шинж:

Гэрчийн мэдүүлэг нотлох баримт болохын тулд юуны түрүүнд нотлох баримтад тавигдах дараах шаардлагыг хангасан тохиолдолд гэрчийн мэдүүлэг нь нотлох баримт болно.

- Нотлох баримтын эх сурвалж нь хүн байна;
- Түүний гарган өгч байгаа мэдээлэл нь хэрэгт ач холбогдолтой байна. Шинжээчийн үүднээс мэдүүлэг өгч болохгүй;
- Мэдүүлэг сэтгэхүйн нотлох баримт учир мэдээлэл нь амаар болон бичгээр түүнчлэн дохио зангаа, зурган хэлбэрээр буюу бусдад ойлгогдох ямар ч хэлбрээр илэрхийлэгдэж болно;
- мэдүүлэг өгөгч үнэн зөв мэдүүлэг өгөх чадвартай байх,
- хуулиар хориглосон субъектүүдээс мэдүүлэг авахгүй байх,
- байцаахдаа хуулиар хориглосон хэлбэрээр асуулт тавихгүй байх,
- мэдүүлэг авахдаа хүний эрхийг хангах.

### **Мэдүүлэгн нотлох баримтын нэмэлт шинж**

**Мэдүүлэг өгөгч үнэн зөв мэдүүлэг өгөх чадвартай байх** шинжид өвчний улмаас хэргийн нөхцөл байдлыг зөв ойлгож, зөв мэдүүлэх чадваргүй болсон эсэхийг ойлгоно. Хүн нөхцөл байдлын талаарх мэдээллийг хүлээн авч, хадгалсан мэдээллийг зөвөөр илэрхийлж чадаж байж түүний өгсөн мэдүүлгийн нотлох чадвар өснө.

Гэрчийн нөхцөл байдлыг талаарх мэдээллийг хүлээн авч, үнэн зөв зөв мэдүүлэх чадварт эргэлзээ үүссэн тохиолдолд шинжилгээ томилж болно.

**Хүн хэрэгт ач холбогдол бүхий мэдээллийг зөвөөр хүлээн авах чадвар.** Хүний бие организм нь мэдээллийн солилцооны эргэлт дээр оршдог. Энэ амрахыг мэддэггүй систем нь зогсоо зайгүй мэдээллийн урсгалуудыг хүлээн авч түүнийг тасралтгүй боловсруулж өөрчилж байдаг.

Хүн хэрэгт хамааралтай нөхцөл байдлын талаарх мэдээллийг харах, сонсох, үнэртэх, амтлах, хүртэхүй зэрэг бусад мэдрэхүйн эрхтнээрээ хүлээн авдаг байна.

Мэдээллийг зөвөөр тусгаж авахад нөлөөлж болох хүчин зүйлст:

- Тухайн үеийн нөхцөл байдал (орчин, цаг агаар, гэрэлтүүлэг, элдэв үнэр тархсан гэх мэт);
- Анализатор (хүлээн авах мэдрэх) нь цочроогч байгаа эсэх. Цочроогчдын эрчимжилтэд хамгийн бага өртөлт үүсэх үед мэдрэхүйд ялгаа үүсдэг;
- Мэдээлэл хүлээн авах үеийн хүний онцлог (согтууруулах, мансууруулах бодис хэрэглэсэн, ядарсан, баярласан, уурласан гэх мэт);
- Тухайн хүний ур чадвар (харах, сонсох чадвар өндөр хөгжсөн, мэргэшлийн хувьд жирийн хүний анзаарахгүй зүйлсийг тогтоон авдаг);
- Тухайн хүний өвчин (мэдрэхүйн эрхтэн гэмтсэн, өвдсөн);



- Өөрөө гэмт халдлагад өртсөн, сэтгэлээс нь гарахгүй огцом хүчтэй өөрчлөлт бий болсон
- Болж өнгөрсөн нөхцөл байдлын онцлог (эд зүйлсийн өнгө, үнэр, хэмжээ, бусад өвөрмөц онцлог);
- Орон зайн харилцаа (тухайн нөхцөл байдлаас хэр хол ойр байсан, бусад юмс үзэгдэлтэй хэрхэн холбогдож байсан, дуу авиа, гэрэлд нөлөөлөх зүйлс);
- Тухайн хүний нас, хүйсийн байдал;
- Тухайн хүний сэтгэцийн өвчин;
- Анхаарлаа төвлөрүүлэх чадвар, цаг хугацаа, орчны боломж.

**Зөвөөр илэрхийлэх чадвар.** Хүн болж өнгөрсөн үйл явдлын талаар санаж байгаа зүйлээ хэрхэн илэрхийлэх чадвараас мэдүүлгийн нотлох чадвар ихээхэн хамаарна.

Хүний ой санамжинд маш олон мэдлэг, сэтгэгдэл, мэдээлэл хадгалагддаг. Гэвч тухайн мөч бүр зөвхөн тодорхой мэдлэг, сэтгэгдлийг л хүлээн авдаг.

Хүний ой тогтоолтод нөлөөлдөг хүчин зүйлээс шалтгаалан тогтоох гэж буй нөхцөл байдлыг мартаж эсхүл сайтар цээжилсэн байдаг. Үүнд:

- сэтгэл хөдлөл,
- нас, боловсрол,
- тухайн хүний зан авир,
- мартагдсан зүйлийг сэргээх буюу өөрчлөхөд нөлөөлсөн бусад зүйлс
- тухайн үе дэх анхаарал төвлөрлийн түвшин,
- ой тогтоолтод нөлөөлдөг зарим өвчин (хумхаа, архи, мансууруулах бодисыг хордлого, хөгшрөлтөөс үүсдэг өвчин),
- цаг хугацаа зэрэг олон хүчин зүйлсээс хамаарна.

Хүний тархин дах холболтын байдал нь гадны нөлөөлөлд мэдэрсэн харилцааг тодоор илэрхийлдэг, хүлээлтийн давалгаа байгаа эсэхтэй нийцдэг. Иймд 3-4 настай хүүхдүүдийн хувьд хүлээлтийн давалгааны ул мөр маш ховор тохиолдолд ажиглагддаг. Арай том хүүхдүүд хэрвээ энэ үеийн явдал нийгмийнхээ нөлөөллийн хувьд тэдэнд танил хүчтэйгээр сэтгэгдэл төрүүлэх юм бол анхаарал нь үүнд чиглэгдэнэ. Томрох тусам хүлээлтийн давалгаа илүү болдог боловч үргэлж нийгмийн хүрээллээс шалтгаалдаг. Хүний сэтгэл зүйн санамсаргүй агшинуудыг тооцох нь шударга шүүн таслах ажиллагаанд практик ач холбогдолтой. Ялангуяа, гэрчийн байцаалт мэтийн байцаан шийтгэх хүнд ажиллагаа явуулахад онцгой ач холбогдолтой.

Хүлээн авсан мэдээллээ боловсуулах, түүнийгээ тодорхой чиглэлд зохион байгуулах, ухамсартай тусгах нь холболтын үндсэн дээр явагддаг. Хүний оюун ухаанд түүний өнгөрсөн амьдралын туршлагаар бэлтгэгдсэн зохих тайлбар өгч чадахуйц чиглэлийн мэдээллүүд илүү бүрэн хэмжээгээр цэгцтэй үлдсэн байдаг. Холболт мэдүүлгийг өгөх шатанд хариу явцын үндсийг бий болгодог. Гэрчийн

шүүхэд туслах тусламж үзүүлэх сэтгэл зүйн бэлэн байдал нь хэрэг бүртгэх, мөрдөх байгууллага ба шүүхийн сонирхож буй нөхцөл байдлыг сануулах, тэдний тухай бүрэн зөв мэдүүлэг өгөхөд хүргэдэг. Гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч мэдүүлэг өгөхөөр сэтгэл зүйн хувьд бэлтгэгдээгүй бол ямар ч зүйлийг нууж, худал мэдүүлэг өгдөг учраас энэ тохиолдолд хэрэгцээтэй чиглэлд түүний сэтгэл зүйн холболтыг өөрчлөхийн тулд олон төрлийн арга хэмжээнүүдийг авч болно. Гэрч хувь хүний сэтгэл зүй ухамсарт нөлөөлсөн илүү оновчтой хэлсэн үг нь гэрчийг бүрэн үнэн зөв мэдүүлэг өгөхөд өдөөж болно. Гэхдээ сэтгэл зүйн хүчтэй холболтой хүмүүсийн хувьд өөрчлөлт маш удан явагддаг гэдгийг тооцох шаардлагатай.

Нэг ижил объектив нөхцөл байдалд нэг адилхан үйл явдлыг тодорхойлсон мэдүүлэгт зөрөө гардаг, сэтгэл зүйд ямар нэгэн өөрчлөлт гарч байгаагаар тайлбарлаж болдог. Илүү тод ухамсаргүй илрэл нь урьд хүлээн авсан мэдээллээ хоромхон зуур ухамсарлалгүйгээр объектийг таних үед объектын төгс цогц синтетик танилт явагддаг ба түүний олон нарийн зүйлс нь ухамсарт нэг мэдрэмжийг өгдөг хэсэгчилсэн таних тэмдгүүдийг илрүүлэх объектын ухамсарт дүгнэлт нь хоёр дах шатыг бүрдүүлдэг. Ингэж таних явцад яагаад гэрч тэр хүнийг таньсан, хэргийн газар, эд мөрийн баримт байгааг хэрхэн мэдсэн гэх мэт зүйлээр мэдүүлэгчээс хариулт авахад хэцүү гэдэг нь ойлгомжтой. Гэвч мэдүүлгийг нотолгооны ач холбогдолтой болгохын тулд урьдах ба дараа дараагийн байцаалтууд өөрөөр хэлбэл объектуудын ижил төстэй байдлыг таних явцдаа алдаа гаргуулахгүйн үүднээс объектын аналитик задлан шинжилгээг ашиглах зорилгыг мөрдөх хэрэгтэй болдог.

Ухамсраар хянагддаггүй сэтгэл зүйн түвшинд ажиллах сэтгэхүйн ажиллагаанаас хамаардаггүй боловч эдгээр хоёр түвшин нь өөр хоорондоо салшгүй холбоотой. Сэтгэхүйг хүчлэх нь шаардлагагүй ба энэ нь олж авсан мэдээллийн үр дүнг энэ түвшинд ухамсартай хэлбэрт шилжүүлэхийн тулд хяналтгүй ухамсрын адилаар тэр түвшинд сэтгэл зүйн ажиллагаа явуулахад түлхэц болдог. Учир нь нэгэнт эхэлчихсэн ухамсарт бус оюун ухааны ажиллагаа цаашид ухамсар дээр суурилсан материалаас хамаарахгүйгээр үйл ажиллагаа явуулдаг. Ийм учраас байцаалт өөр нөхцөл байдлын тухай яригдаж байх үед гэрчийн санаанд ямар нэгэн хүний нэр, хаяг санаанд нь орж байдаг. Ухамсаргүй илэрлийн асуултууд ба түүний мэдүүлэг бий болоход нөлөөлөх нь гэрчийн байцаалтын тактикийг бий болгосны үр дүнд боловсруулагдаж эхэлдэг ба энэ нь цаашид маш их судалгаа, шинжилгээний ажил хийхийг шаардаж байдаг.

Хүний ухамсаргүйгээр мэдүүлсэн мэдүүлгийг бид яагаад, юуны тулд энэ үйлдлийг дахин дахин яриад байгаа гэдгийг нь ойлгосны үндсэн дээр түүний мэдүүлгийг бүрэн хэмжээгээр илүү гүн гүнзгий боловсруулж чадна.

Мэдүүлэг өгөгчөөс асуултаа хэрхэн ойлгогдохоор тавьж байгаагаас тухайн хүн үнэн зөв мэдүүлэг өгөх эсэх нь хамаардаг. Иймд хуулиар тулгасан, хөтөлсөн асуулт тавихыг хориглодог.



## Хуулиар хориглосон субъектүүдээс мэдүүлэг авахгүй байх

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрчээр байцаагдаж болохгүй хүмүүсийг хуульчилдаг. Үүнд:

- тухайн хэргийг урьд нь хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байсан шүүгч,
- тухайн хэрэгт хяналт тавьж, яллах чиг үүрэг гүйцэтгэж байсан прокурор,
- өмгөөлөх, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргээ гүйцэтгэж байх явцад тухайн хэргийн байдлыг мэдэх болсон өмгөөлөгч.

Монгол Улсын иргэний гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгч болохгүй гэсэн хуулийн заалтыг тайлбарлалгүйгээр байцааж мэдүүлэг авсан бол нотолгооны ач холбогдлоо шууд алдана. Энэ нь нотлох үйл ажиллагаанд хориг саад учруулж байгаа явдал биш бөгөөд хүмүүнлэг ёсны зарчмын ёс суртахууны үндсийг хуульчлахдаа нэг талаас гэр бүл, төрөл төрөгсдийн харилцааны монгол уламжлал, зан заншлыг тусгахын тулд нөгөө талаас эцэг эх, үр хүүхэд, эхнэр нөхрийн харилцааг бие биед нь сөргүүлэн тавих явдалд албан ёсны түлхэц үзүүлж болох нөхцөлийг хаах баталгаа болж байгаа юм.

Дараах тохиолдолд гэрчийн мэдүүлгийн нотолгооны ач холбогдол буурдаг байна:

1. Тухайн гэрч нь нийгэмд харш зан үйл байнга гаргаж байсан. (Архидан, согтуурдаг буюу мансуурагч,)
2. Удаа дараа худал мэдүүлэг өгч байсан болох нь тогтоогдсон.
3. Хэрэг хариуцах чадваргүй буюу эрх зүйн чадвар, чадамжгүй.
4. Тухайн хэрэгт ямар нэг байдлаар хувийн сонирхолтой байгаа бол.
5. Гэрч нь эсрэг мэдүүлэг өгч байгаа этгээдүүдийн төрөл садан, найз нөхөд, өштөн дайсан байгаа тохиолдолд.
6. Гэрч ямар нэг байдлаар эрх ашиг нь хөндөгдөн ЭБША-нд оролцож байгаа этгээдийн эрхшээлд байгаа бол. (албан тушаал, эд хөрөнгө, байр, орон сууц гэх мэт).
7. Нөхцөл байдлыг тусган авах үед гэрч бие махбодийн болон сэтгэл санааны хувьд ямар байсан.(сандарсан, уурласан, сэтгэл санааны гүн хямралд орсон гэх мэт).
8. Гэрчийн гарган илэрхийлж байгаа мэдээллийг гэрч тухайн үед тогтоох чадваргүй байсан буюу чадвар сул байсан нь тогтоогдсон бол (мартамхай, өнгө ялгагдаггүй гэх мэт).

Дээр дурьдсан нөхцөл байдлууд нь тухайн нотлох баримтын нотлох чадварыг шууд бууруулахгүй боловч нотлох баримтыг үнэлэхэд ихээхэн ач холбогдолтой.



Гэрчээс дэвшүүлсэн сэжиг, таамаглал нь нотлох баримт болохгүй. Хэрэв бусад нөхцөл байдлын уялдаа холбоог нарийн тооцож тайлбарласан гэрчийн таамаглал, төсөөлөл, дүгнэлт нь бусад нотлох баримтаар тогтоогдвол туслах нотлох баримт болж болно. Харин үндсэн буюу нэгдүгээр зэргийн нотлох баримт болохгүй;

## ДАСГАЛ АЖИЛ:

“Бураагаа хүлээсэн хүний мэдүүлэг бол нотлох баримтын хаан” гэдэг томъёоллыг тайлбарлан ярилцана уу?

1. Иргэн С-ийг лоомоор цохиж алсан гэмт хэрэг үйлдэгджээ. Үүнийг сэтгэл мэдрэлийн өвчтэй Л харжээ. Тэр С-ийг муухай Бааяа газар цохьдог юмаар ийшээ цохьсон гэж толгой руугаа заажээ. Муухай Бааяа аль байна гэхэд Баяраа гэдэг хүнийг заажээ. Баяраа би наадахад чинь чихэр өгөөгүй юм, тэгээд хорондоо намайг гүтгэж байна гэв.  
Шүүх эмнэлэгийн дүгнэлтээр Л нь хэрэг хариуцах чадваргүй гэхдээ тухайн болсон үйл явдлыг ойлгож, зөвөөр тайлбарлах чадвартай гэсэн дүгнэлт гаргажээ.  
Л-ийн мэдүүлэг нотлох баримт болох уу?  
Л-ийг гэрчээр байцааж болох уу? Болох бол ямар журмаар байцааж мэдүүлгийг нь бэхжүүлж авах вэ?
2. Хохирогч Д гэмт хэргийн улмаас хараагүй болжээ. Тэрээр нөхцөлбайдлыг маш сайн тодорхойлон хэлж чадаж байв.  
Д-ийн мэдүүлэг нотлох баримт болох уу?
3. Гэрч Найдан мэдүүлэхдээ Балсан компьютерийнхээ рамыг сольсон байсныг би харсан гэж мэдүүлжээ. Найдан нь тухайн нөхцөл байдал болох цаг үед компьютерийн талаар ямар ч мэдлэггүй байсан бол түүний мэдүүлэг нотлох баримт болох уу?
4. Хохирогч дээрмийн халдлагад өртөх үедээ их хэмжээний согтолттой байсан ба сэжигтнийг шууд заажээ.  
Хохирогчийн мэдүүлэгт үнэлэлт өг?

### Хяналтын асуулт:

1. Мэдүүлгэн нотлох баримт бий болоход хүний ой ухаан ямар үүрэгтэй вэ?
2. Хүн мэдээллийг хүлээж авахад нөлөөлөх хүчин зүйлийг нэрлэж тайлбарлана уу?
3. Хүний мэдээлэл хүлээн авах чадварт сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлийг нэрлэж тайлбарлана уу?
4. Хүн мэдээллийг хүлээж авахад нөлөөлдөг байгаль цаг агаарын нөхцөл байдлын талаар ярьж тайлбарлана уу?
5. Хүн яагаад болсон байдлыг ямар нэгэн алдаатай хүлээн авдаг вэ?
6. Сэтгэл мэдрэлийн хүнд өвчтэй хүн ямар түвшинд мэдээлэл хүлээж авч болох вэ?





## СЭДЭВ 10. БИЕТ НОТЛОХ БАРИМТ

**Сэдвийн зорилго:** *Биет нотлох баримт, түүний бүрдэх, өөрчлөгдөх, цуглуулж, бэхжүүлж авах зэрэг олон онцлогийг харгалзан тэдгээрийг шүүхээр хэлэлцүүлэх эсэх, шийдвэрийн үндэслэл болгох эсэх гаргалгааг хууль зүйн төдийгүй онолын үндэслэлтэй гарган тэтгэлзэхэд шаардлагатай мэдлэг, хандлага төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.*

Хэргийн талаархи мэдээллийг агуулж буй материаллаг, бодит зүйлсийг биет баримт гэнэ.

Биет баримт дараах байдлаар илэрч болно:

- Эд мөрийн баримт,
- Баримт бичиг,
- Бичмэл баримт,
- Байгаль орчин,
- Гэрэл болон гар зураг,
- Дүрс, дууны бичлэг болон шинжлэх ухаан технологийн дэвшлийг ашиглан буулгасан зүйлс,
- Бусад.

Шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хирээр шинэ төрлийн нотлох баримтууд бий болсоор байдаг ба үүний нэг нь вертиуль нотлох баримт юм. Энэ нь компьютер болон түүний сүлжээндхадгалагдаж байгаа буюу түүгээр дамжиж байгаа мэдээлэл байдаг. Энэ төрлийн нотлох баримт нь харахад бодитойгоор оршиж байгаа мэт боловч ямар ч ул мөргүйгээр маш амархан устах буюу хэлбэрээ өөрчлөх, зарим тохиолдолд өөрийгөө хуулан олшруулж, тэр ч бүү хэл тодорхой хугацаагаар “нуугдаж” алга болдог онцлогтой.

### **Биет баримтын давуу тал:**

- хэргийн нөхцөл байдлын талаар илүү бодитой мэдээлэл олж авах боломжийг олгодог,
- ямар нэгэн өөрчлөлт орсон эсэхийг тогтоох боломж илүү,
- мэдээлэл үүсч бий болсон зүй тогтлыг тогтоох боломж харьцангуй өндөр.

### **Сул тал:**

- биет нотлох баримтаас мэдээлэл авахад зөвхөн түүнтэй харьцаж буй хүний мэдлэг, ур чадвараас шалтгаалдаг,

- гадны нөлөөнд орж өөрчлөгдөх магадлал их,
- дахин сэргэхгүйгээр устах боломж өндөр, тухайлбал, гэрчийн мэдүүлэг утсан тохиолдолд бусад гэрчүүдийн мэдүүлгээр тогтоож болдог бол биет баримтуудыг устахад дахин сэргэх нь ихээхэн хүндрэлтэй.

## **Биет нотлох баримтын үндсэн шинж:**

- агуулгын хувьд тухайн гэмт хэрэг хамааралтай байна;
- хэрэгт хамааралтай нөхцөл байдал нь мэдээлэл хэлбэрээр илэрнэ;
- мэдээлэл нь эх сурвалжтай байна;
- эх сурвалжтодорхой байна;
- мэдээллийг эх сурвалжаас хуулийн дагуу олж авсан байна.

## **Биет нотлох баримтын нэмэлт шинж:**

- Материаллаг бодитой байх
- Биет нотлох баримтад ул мөр нь үүссэн зүй тогтол, шалтгаант холбоо нь эргэлзээгүй байх
- Биет нотлох баримтын хэлбэр дүрс, шинж чанар алдагдаагүй байх
- Биет нотлох баримтыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хураан авч, бэхжүүлсэн байх

## **БИЕТ НОТЛОХ БАРИМТЫН НЭМЭЛТ ШИНЖ:**

### **1. Материаллаг, бодитой байх**

Биет нотлох баримт нь өөрийн гэсэн орон зайд бодитойгоор оршиж, түүнийг хэмжиж, жигнэж үзэх бололцоотой материаллаг зүйлсээс бүрдэнэ.

Үүнд: амьтан (гэмт хэргийн ач холбогдол бүхий мэдээлэл агуулагч амьтад), эд зүйл (гэмт хэргийн ач холбогдол бүхий мэдээлэл агуулагч бодитойгоор оршин буй материаллаг юмс), бичиг баримт (мэдээллийг бичмэл байдлаар хадгалж буй зүйлс), орчин (гэмт хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл агуулж буй хүрээлэн байгаа орчин) байна.

**Хүн, нотлох баримтын эх сурвалж болж байгаа тохиолдолд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:**

1. Мэдээлэл нь хүний бие дээр бодит байдлаар илэрч болно. Үүнд: Шарх, сорви, шивээс, будагдсан буюу бохирлогдсон байдал болон бусад ул мөр,
2. Мэдээлэл нь хүний биед агуулагдаж болно. Жишээлбэл, цогцос, хүний эд, эрхтэн нотлох баримтын эх сурвалж болно.

**Эд зүйл нотлох баримтын эх сурвалж болж байгаа тохиолдолд дараах шаардлага хангасан байна.**



1. Эд зүйл нь бодитойгоор оршин байх ёстой. Хийсвэрээр буюу мэдээлэл хэлбэрээр тэр шинжийг бүрэн тодорхойлох боломжгүй. Ихэвчлэн хүний хөдөлмөрийн үр дүнд бий болдог.
2. Гэмт хэргийн ул мөрийг агуулсан байх бөгөөд энэ нь ямар ч хэлбэрээр илэрнэ.
3. Хаанаас ямар байдалтай олдсон, олж авсан нь тодорхой байх ёстой.
4. Эд зүйл нь цогцоороо буюу хэсэг, эд ангиараа байж болно.

**Бичиг баримт, нотлох баримтын эх сурвалж болохын тулд дараах шаардлагыг хангасан байна.**

1. Бодитойгоор орших ба хийсвэр байдлаар байж болохгүй.
2. Гэмт хэргийн ул мөрийг бичгэн буюу зурмал хэлбэрээр агуулсан байна. (Заавал цаасан дээр байх шаардлагагүй)
3. Хүний идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд бий болсон байна. Үүнд зурах, бичих, тэмдэглэх зэрэг үйл ажиллагааны үр дүнд бий болсон байх ба ямар зүйлээр бичиж тэмдэглэсэн нь хамаарахгүй.

**Орчин, нотлох баримтын эх сурвалж болох тохиолдолд дараах шаардлагыг хангасан байна.**

1. Орчин нь биднийг хүрээлэн буй орчин байна (Ой мод, гол мөрөн, хад асга, гудамж, хороолол, хогийн цэг). Өөрөөр хэлбэл, энэ нь маш олон баримтуудыг өөртөө агуулсан цогц ойлголт.
2. Тухайн нотлох баримтын эх сурвалжийг хураан авах боломж хязгаарлагдмал байна.

**Амьтан, нотлох баримтын эх сурвалж болоход дараах шаардлагыг хангасан байна.**

1. Биологийн биет байна. Түүний үхсэн, амьд нь нотолгооны чанарт нөлөөлөхгүй.
2. Тухайн амьтанг бэхжүүлэн хураан авах боломж хязгаарлагдмал.
3. Түүний үйл хөдлөл, зан авир нь мэдээлэл агуулж болно.

**Ургамал, нотлох баримтын эх сурвалж болоход дараах шаардлагыг хангасан байна.**

1. Биологийн биет байна. Түүний үхсэн, амьд нь нотолгооны чанарт нөлөөлөхгүй.
2. Ургамал нь оршин байгаа байдал, хэлбэрээс нь шалтгаалан хураан авах боломж харилцан адилгүй.
3. Ургамлын ургах процесс нь өөрөө мэдээлэл агуулах боломжтой.

Нотлох баримтын эх сурвалж нь бодит байдал дээр материаллаг хэлбэрээр оршин байгааг тогтоосноор түүний өөрчлөгдөх, хувьсах зүй тогтлыг судлан цуглуулж, бэхжүүлэх арга замыг зөв шийдвэрснээр нотлох үйл ажиллагааг түргэн шуурхай явуулах, төрөл бүрийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тактикийн болон шинжлэх ухаан, технологийн ололт амжилтыг ашиглан

түүнээс ач холбогдол бүхий мэдээлэл олж авах боломжийг нэмэгдүүлдэг. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухаан, технологийн хөгжил өндөрсөх тутам нотлох баримтын эх сурвалжаас олон мэдээлэл олж авах боломж улам өргөжинө.

## **2. Биет нотлох баримтад ул мөр нь үүссэн зүй тогтол, шалтгаант холбоо нь эргэлзээгүй байх**

Ул мөр буюу мэдээлэл үүсэх зүй тогтол тэр дундаа биет зүйл дээр хэрхэн үүсдэг талаар шинжлэх ухаан, технологийн ололт дээр тулгуурлан ойлгож, мэдэх бүрэн боломжтой. Зарим тохиолдолд ямар нэгэн тусгай арга хэрэглэхгүйгээр ч биет нотлох баримтад ул мөр үлдсэн зүй тогтол, шалтгаант холбоог тогтоох ч тохиолдлууд олонтой гардаг.

Гэхдээ зүй тогтол нь бүрэн судлагдаж тогтоогдоогүй, эсвэл тун ховор онцгой тохиолдолд ул мөр үүсэх зүй тогтол, шалтгаант холбоо алдагдаж болохыг анхаарч биет нотлох баримтад үнэлгээ өгнө. Тухайлбал, 53 хүн алсан хэмээн шийтгэгдсэн Андрей Чикатилогийн үрийн шингэн 4-р бүлгийнх байхад цус нь 2-р бүлгийнх байжээ. Өөрөөр хэлбэл, хохирогчийн биенээс 4 дүгээр бүлгийн үрийн шингэн олджээ. Уламжлалт ойлголтоор цус мөн тийм байх ёстой байдаг учир цагдаагийнхан 4-р бүлгийн цустай хүн хайх явцдаа түүнийг сэжиглэн барьсан боловч 2 дугаар бүлгийн цустай байсан учир суллаж түүнийг дахин зургаан жил цуст яргаллаа үргэлжлүүлэх боломж олгосон гашуун түүх бий.

## **3. Биет нотлох баримтын хэлбэр дүрс, шинж чанар алдагдаагүй байх**

Хэргийн бодит үнэнийг тогтоож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр гаргахад биет баримтыг судалж, харьцуулан дүгнэлт хийх үед оролцогчдод үзүүлэх шаардлага гардаг. Энэ үед тухайн биет нотлох баримтын бүрэн бүтэн, шинж чанар өөрчлөгдөөгүй байх нь илүү чухал байдаг тул хэрэг бүртгэгч, мөрдөгч, прокурор, шүүгчээс нотлох ажиллагааны баталгааны талаар мэдлэг чадвартай байх нь чухал.

## **4. Биет нотлох баримтыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хураан авч, бэхжүүлсэн байх**

Биет нотлох баримт нь ихэвчлэн хувь хүн, хуулийн этгээдийн эзэмшилд байдаг тул тэдгээрийг ихэвчлэн хуульд заасан үндэслэл журмын дагуу хураан авч, цуглуулж бэхжүүлдэг.



## **БИЕТ НОТЛОХ БАРИМТ ХАМГААЛАХ**

Биет нотлох баримт гадны нөлөөнөөс шалтгаалан устах, өөрчлөгдөх магадлал өндөртэй тул тэдгээрийг хадгалах, хамгаалах, тээвэрлэхэд тусгай журам шаардлагатай байдаг.

### **Биет нотлох баримт хамгаалах**

Биет нотлох баримтыг хамгаалах гэдэг нь хэрэгт ач холбогдол бүхий мэдээллийг агуулагч нотлох баримтын эх сурвалжийг гадны ямар нэг нөлөөллөөс хамгаалж нотолгооны ач холбогдлыг бууруулахгүй байхад чиглэгдсэн арга хэрэгсэл, нөхцөл байдлыг хэлнэ.

### **Нотлох баримт тээвэрлэх**

Биет нотлох баримтыг тээвэрлэх гэдэг нь хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл агуулагч нотлох баримтын эх сурвалжийн бүрэн бүтэн байдал, нотолгооны ач холбогдлыг алдагдуулахгүйгээр нэг газраас нөгөө газар уруу зөөвөрлөх үйл явц юм.

Биет нотлох баримтыг тээвэрлэх явцад өнөөгийн эрүүгийн нөхцөл байдал хүндэрч байгаа үед халдлага хийхгүй гэсэн баталгаа алга. Ингэсэн тохиолдолд нотлох баримт устаж гэмтээд зогсохгүй хүний амь нас, эрүүл мэнд хохирч болно.

Мөн биет нотлох баримтыг тээвэрлэх, зөөвөрлөх явцад хүн нотлох баримтыг үрэгдүүлсэн, устгасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо манайд байхгүй. Хэн нэгэнд хариуцлага хүлээлгэсэнээр энэ асуудал шийдвэрлэгдэхгүй хамгийн гол нь тухайн ажиллагааг хэрхэн хийх ёстойг хуульчлан зохицуулах нь чухал.

### **Биет нотлох баримт хадгалах**

Биет нотлох баримтыг хадгалах гэдэг нь хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл болон нотлох баримтын эх сурвалжийн бүрэн бүтэн байдал, нотолгооны ач холбогдлыг алдагдуулахгүйн тулд тодорхой нөхцөл байдалд байлгах үйл явц юм.

Биет нотлох баримтыг хадгалах журмыг хууль, тогтоомжоор зохицуулдаг.

## ДАСГАЛ АЖИЛ:

“Эд мөрийн баримт бол дуугүй гэрч” гэдэг томъёоллыг тайлбарлан ярилцана уу

1. Дорнод аймгийн төв орших баамын гэгдэх байранд орших ломбардаас онц, их хэмжээний мөнгө хулгайлагдсан хэрэгт шаардлагатай ЭБШ тодорхой ажиллагаа явуулсны үр дүнд дээврийг нь цоолж орсон гэж үзэж болохоор нөхцөл байдал тогтоогджээ. Дээвэр дээрээс үл таних хүний 41, 43 размерийн гуталны мөр олдсон бөгөөд түүнийг шалгах явцад шинжээч хамгийн түрүүнд дээврийн хонгил руу ганцаараа орж уг мөрийн бэхжүүлж авсан учир түүний мөр болох (41 размерийн гутал) нь нотлох баримтаар тогтоогдсон.

Ж. гэгчийг гэмт хэрэг үйлдсэн байж болох талаар “гэх ажлын багагүй мэдээлэл цугласан ба түүний гэрт нэгжлэг хийхэд хохирогчийн тусгайлан тэмдэглэл үлдээсэн 10.000 төгрөг олдсон бөгөөд уг мөнгийг хаанаас хэрхэн олж авснаа санахгүй гэж мэдүүлсээр.

Ж. нь 39 размерийн гутал өмсдөг ба хэргийн газрын үзлэгт оролцож мөр бэхжүүлж авсан шинжээчтэй нэг ангид сурч байсан үй зайгүй найзууд байжээ. Гэвч тэрээр тухайн аймагт урд нь ирж байгаагүй ирээд гурван сар л болж байгаа хэрэг гарах үед ирээд дөнгөж нэг сар болж байсан ба нутаг орныг сайн мэддэггүй тогтоогджээ. Түүнчлэн гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө удахгүй их хэмжээний бэлэн мөнгөтэй болно гэж ярьж байсан гэхдээ би сайн санахгүй байна гэсэн тухайн аймгийн цагдаагийн хар дансанд бүртгэлтэй архаг архичин Л.-ийн гэрчийн мэдүүлгээс өөр нотлох баримт байхгүй байв.

*Асуулт:* Мөрдөгч Ж.-гийн үйлдэл хангалттай нотлогдсон гэж үзэн шүүхэд шилжүүлжээ.

*Асуулт:* Эд мөрийн баримт нь эрүүгийн хэрэгт нотлох баримт болох уу?

Мөрдөгчийн үйлдэлд хууль зүйн үүднээс дүн шинжилгээ хийнэ үү?

Нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж ярилцана уу?

*Хяналтын асуулт:*

1. Биет нотлох баримтыг үнэлэх ажиллагаа нь бусад төрлийн нотлох баримтыг үнэлэхээс ялгаатай болон төстэй талыг тодорхойлон ярилцана уу?
2. Биет нотлох баримтыг үнэлэхэд анхаарах асуудлыг тодорхойлон тайлбарлана уу?
3. Биет нотлох баримтын нотолгооны ач холбогдлыг бууруулахад нөлөөлөх асуудлыг тодорхойлон тайлбарлана уу?
4. Биет нотлох баримтын нотлох чадвар нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлон тайлбарлана уу?



## СЭДЭВ 11. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, МЭДҮҮЛЭГ

**Сэдвийн зорилго:** *Шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, түүний онцлогийг харгалзан түүнийг шүүхээр хэлэлцүүлэх эсэх, шийдвэрийн үндэслэл болгох эсэх гаргалгааг хууль зүйн төдийгүй онолын үндэслэлтэй гарган мэтгэлзэхэд шаардлагатай мэдлэг, хандлага төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.*

Шүүх, албан тушаалтны шийдвэрээр томилогдсон шинжлэх ухаан, техник, урлаг болон гар урлал зэрэг тусгай мэдлэгийг сайн эзэмшсэн хүн, нотлох баримтын эх сурвалжаас хэрэгт ач холбогдол бүхий мэдээллийг тусгай арга хэрэгслийг ашиглан олж авснаа бичгээр тайлбарлаж байгаа нотлох баримтын нэгэн төрлийг **шинжээчийн дүгнэлт** гэнэ.

Шинжээчийн дүгнэлтийн зарим агуулгыг тайлбарлуулах, арга, аргачиллыг тодруулах зорилгоор мэдүүлэг авдаг болохоос шинээр нөхцөл байдлыг илрүүлэн гаргах зорилгогүй.

Шинжээчийн дүгнэлтийг цуглуулах, бэхжүүлэх ямар нэг нэмэлт ажиллагаа явуулалгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ашигладаг.

Шинжээчийн дүгнэлт, мэдүүлгийн үндсэн шинж:

- Агуулгын хувьд тухайн гэмт хэрэг хамааралтай байна;
- Хэрэгт хамааралтай нөхцөл байдал нь мэдээлэл хэлбэрээр илэрнэ;
- Мэдээлэл нь эх сурвалжтай байна;
- эх сурвалж нь тодорхой байна;
- Мэдээллийг эх сурвалжаас хуулийн дагуу олж авсан байна.

Шинжээчийн дүгнэлт, мэдүүлгийн нэмэлт шинж:

- Шүүх, прокурор хууль сахиулагчаас шинжээч томилох тухай шийдвэр гаргасан байна;
- Шинжээч томилох, түүнд шийдвэр танилцуулах явц хуулийн дагуу байх;
- Шинжээчийн тогтоох гэж байгаа асуудал нь түүний мэдлэг, ур чадвараас хэтрээгүй байх ёстой;
- Шинжээчийг заасан татгалзан гаргах хуульд заасан үндэслэл байхгүй байна.

Шинжээч нь тогтоолд дурьдсан нөхцөл байдлыг тогтоохоос гадна уг хэрэгт ач холбогдол бүхий бусад зүйлийг олж тогтоосон бол энэ талаар асуулт тавиагүй байсан ч өөрийнхөө дүгнэлтэд заах үүрэгтэй. Энэ нь нотолгооны ач холбогдолд нөлөөлөхгүй.

Шинжээчид ирүүлсэн биет нотлох баримт нь жинхэнэ эхээрээ байх ёстой. Хуулбар нотлох баримтын эх сурвалжаас хэрэгт ач холбогдол бүхий мэдээллийг бүрэн хэмжээгээр авч чадахгүйд хүрч улмаар нотолгооны ач холбогдлыг бууруулна.

Хуульд заасан тохиолдолд шинжилгээг заавал хийлгэдэг.

## **Шинжээчийг дүгнэлт, мэдүүлгийг үнэлэхэд анхаарах асуудал**

Шинжээчийн дүгнэлтийг шүүх баримтлах баримтлах үүрэггүй боловч дүгнэлтийг зөвшөөрөхгүй байгаа бол үндэслэлээ заана.

Шинжээчийн дүгнэлтийг бусад нотлох баримтууд болон тогтоогдсон нөхцөл байдлын улмаас бий болсон өөрийн дотоод итгэлдээ тулгуурлан үнэлнэ.

Шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд дараах нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

- шинжээчийн онолын мэдлэг, практик, дадлага туршлага,
- шинжээчид өгсөн баримт нь дүгнэлт гаргахад хангалттай байсан эсэх,
- дүгнэлт гаргахдаа ямар арга, хэрэгсэл ашигласан болох, энэ нь шинжлэх ухааны болон практикт хэр шалгагдсан,
- шинжилгээнд ирүүлсэн нотлох баримт (биет нотлох баримт) нь мэдээлэл өгөх чадвар хэр байсан,
- шинжээчийн дүгнэлт нь бусад нотлох баримтуудтай хэрхэн уялдаж байгаа болох,
- тогтоолд дурдагдсан асуултад хэр оновчтой, тодорхой хариулсан болох.

Хэрэв өргөн хэрэглэж хэвшээгүй шинжлэх ухаан, техникийн шинэ ололтыг ашигласан тохиолдолд түүний шинжлэх ухааны үндэслэлийг тайлбарласан байвал зохино.

Шинжээч нар санал зөрж өөр өөрөөр дүгнэлт гаргасан тохиолдолд хэрэг шүүх хэрэгт цугларсан нотлох баримтад үндэслэн өөрийн дотоод итгэлээрээ үнэлнэ.





## ДАСГАЛ АЖИЛ:

“Шинжлэх ухаан бол дөрөв дэх шүүгч” гэсэн томъёоллын утгыг тайлбарлан ярилцана уу?

1. Анхны, давтан, комисстой шинжилгээ хийлгэхэд 4 өөр дүгнэлт гарчээ. Анхны, давтан шинжилгээний хариу өөр өөр гарснаас гадна комисстой хийсэн шинжилгээнд оролцсон 1 шинжээчийн дүгнэлт зөрсөн тул тэрээр тусдаа дүгнэлт гаргажээ. Шүүх хурал дээр шинжээчдийг гэрчээр байцаах явцад тэд өөрсдийнхөө дүгнэлтийн үнэн зөвийг шинжлэх ухааны үндэслэлтэй хамгаалахын зэрэгцээ бусад шинжээчдийн үндэслэлтэй дүгнэлтийг няцаажээ. Шинжээчийн дүгнэлт, мэдүүлгийг үнэлэн ярилцана уу?
2. Шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх явцад үл мэдэгдэх шалтгаанаар шинжээчийн дүгнэлт алга болжээ. Прокурор шинжээчийн дүгнэлтийг баталгаажуулахаар шүүхэд шинжээчийг гэрчээр дууджээ. Нөхцөл байдлыг үнэлэн ярилцана уу?

